

Орлого : 6,031,200 төгрөг

- Үйлчлүүлэгчээс авах үйлчилгээний орлого
 $3,500 \text{ төг} \times 40 \text{ хүн} \times 14 \text{ хоног} \times 3 \text{ ээлж} = \underline{5,880,000 \text{ төгрөг}}$
- Арьс борлуулсан орлого $2,500 \text{ төг} \times 14 \text{ хоног} \times 3 \text{ ээлж} = \underline{105,000 \text{ төгрөг}}$
- Байгаль орчныг хамгаалах хураамжийн орлого
 $(150 \text{ төг (нэг хүн)} \times 4 \text{ хүн} + 500 \text{ төг (нэг машин)}) \times 14 \text{ хоног} \times 3 \text{ ээлж} = \underline{46,200 \text{ төгрөг}}$

Зардал : 5,494,575 төгрөг

- Тэмээний сүү: $650 \text{ төг/л} \times 60 \text{ л} \times 14 \text{ хоног} \times 3 \text{ ээлж} = \underline{1,638,000 \text{ төгрөг}}$
- Хоол: мах $900,000 \text{ төг}$ + хоолны зардал $1,000,000 \text{ төг} = \underline{1,900,000 \text{ төгрөг}}$
- Цалин хөлс: (ус зөөх $25,000 \text{ төг/ээлж}$, аргал түүх $20,000 \text{ төг/ээлж}$, тогооч $30,000 \text{ төг/ээлж} \times 2 \text{ хүн}$, байгаль орчны байцаагчийн цалим $15,000 \text{ төг/ээлж}$) $\times 3 \text{ ээлж} + \text{мал нядлах } (1,500 \text{ төг} \times 14 \text{ хоног} \times 3 \text{ ээлж}) = \underline{423,000 \text{ төгрөг}}$
- Машины бензин: 210,000 төгрөг
- Худгийн засвар үйлчилгээний зардал: 62,775 төгрөг
- Ус цэвэршүүлэх төхөөрөмжийн засвар үйлчилгээний зардал · байгууламжийн шинэчлэлийн зардлын хуримтлал: 260,800 төгрөг
- Бусад байгууламжийн засварын зардал: 1,000,000 төгрөг (гал тогооны засварын барилгын материал, аяга таваг, хөшиг, дэр, гудас хөнжил зэрэг)

Ашиг : 536,625 төгрөг

- 4) Төслийн хэрэгжилтийн тогтолцоог бий болгоход тулгарч буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам

Бүрдэний сувиллын газрын эмчилгээнд наранд халсан байгалийн элсийг хэрэглэдэг тул үйл ажиллагаанд нь цаг уурын хүчин зүйл ихээхэн нөлөөлдөг байна. Гэвч үйлчлүүлэгчдийг олноор ирүүлэх ба сүү нийлүүлэх малчдыг сувиллын газрын ойролцоо нутаглуулах нь төслийн хэрэгжилтийн тогтолцоог бий болгоход хамгийн чухал зүйл болох юм. Иймд сумын захиргаанаас үйлчлүүлэгч болон малчдад сурталчилгаа явуулах, холбоо барих, мэдээлэл өгөх шаардлагатай байна. Ялангуяа үйлчлүүлэгчийн тоог энэ жилээс нэмэгдүүлэх (нэг ээлжинд: 30→40 үйлчлүүлэгч) зорилго тавьж байгаа ба улмаар үйлчилгээний үнийг нэмэх (2,500 төгрөг→3,500 төгрөг)–ийн тулд үйлчлүүлэгчдэд учир явдлыг тайлбарлах шаардлагатай ба энэ зорилгоор сум сувиллын газрын танилцуулга хийж, Улаанбаатар болон Сайншанд хотын байгууллагуудад тараасан байна. Үйлчилгээний үнэ нэмэх тухайд үйлчилгээнд хэрэглэх ингэний боловсруулсан сүүний хэмжээг нэмэгдүүлсэн, худаг байгуулсан, ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулж усны чанарыг сайжруулсан зэрэг үйлчилгээний чанарыг бодитойгоор дээшлүүлсэн гэсэн үүднээс үйлчлүүлэгчдэд ойлгуулахыг хүсэв. Нөгөө талаар малчдад үйлчлүүлэгчдийн тоо, захиалах сүүний хэмжээ, малчин тус бүрт оногдох ингэний боловсруулсан сүүний хэмжээ зэргийг шуурхай мэдээлэх шаардлагатай юм. Ийм байдлаар Бүрдэнэд

нутаглаж, сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах малчидтай найдвартай харилцаа тогтоож явах нь чухал байна.

(4) Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах төслийн биелэлт

1) Сувиллын газрын 2004 оны үйл ажиллагаа эхлэхээс хүртэлх бэлтгэл ажил (2003 оны 10 сараас 2004 оны 6 сар)

i) Бүрдэний өрөмдмөл худгийн ажил (2003 оны 11 сар)

Урьд өмнө ундарга арвинтай Бүрдэний булгуудыг тойроод малчдын өвөлжөө байдаг байжээ. Гэвч хэдхэн жилийн өмнөөс усны ундарга багасаж, булгууд ширгэснээр айлууд өвөлжихөө больж, зун болоход сувилалд сүү, цагаа зардаг хэдхэн айл ирж буудаг болжээ. Сувиллын ойролцоо байдаг гар худаг байдаг ч ундарга муутай. Ингээд малчдыг усны гачаалаас гаргаж, найдвартай эх үүсвэрээр хангах, сувиллын газрын ундны усны хангамжийг сайжруулах зорилгоор Бүрдэнэд өрөмдмөл худаг гаргасан болно. Худаг ашиглах малчдын бүлгийн ахлагч өөр тийш шилжин явсан, үлдсэн бүлгийнхэн эдийн засгийн чадвар муу тул худгийн ашиглалт, засвар үйлчилгээний сан байгуулахаас гадна Сумын худгийн санд төлбөр хийхэд тодорхой бэрхшээл үүссэнийг харгалзан үзэж эдгээр зардлын 70 %-ийг сумын ЗДТГ гаргахаар болсон юм.

ii) Ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулсан тухай (2004 оны 5-6 сар)

Гэвч ихээхэн найдвар тавьж байсан өрөмдмөл худгийн усны чанар муугаас ундны усанд тохирохгүй нь тогтоогдсон тул ус цэвэрлэх төхөөрөмжийг ашиглах боломжийг судалж үзсэн юм. Ингээд 6-р сарын 21-нд сувилал нээгдэхээс өмнөхөн худгийн дэргэд сумын ЗДТГ-аас барьж өгсөн зориулалтын байранд эсрэг нэвтрэлтийн мембрант шүүлтүүр бүхий ус цэвэршүүлэгч төхөөрөмжийг суурилуулсан болно. Ус цэвэршүүлэх төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний зардал болон элэгдэл хорогдлын шимтгэлийг сувиллын газрын орлогоос гаргахаар болов.

iii) Сурталчилгааны үйл ажиллагаа (2004 оны 4-5 сар)

Сувиллын газрын менежментийг сайжруулах ажлын хүрээнд сувилуулагчид болон сүү борлуулах малчдад чиглэсэн сурталчилгааны үйл ажиллагаа явуулах шаардлагатай боллоо. Сумын ЗДТГ-аас аймаг, хотын эмнэлэг ажил төрлийн холбоотой сумдуудтай утсаар ярих, хэл хүргүүлэх зэрэг арга хэмжээг авсан болно. Ялангуяа гүний худаг, болон ус цэвэршүүлэх төхөөрөмж ашиглах болсноор ундны усны хангамж, чанар сайжирсан болон худалдан авах сүүний хэмжээ, үнийг нэмэгдүүлснээр олон малчинд сүү борлуулах боломж нээгдэж буй зэргийг голлон тайлбарлав. Ингээд 4-р сарын сүүлээр сумын ХАА-н түшмэл багийн дарга нараар дамжуулан сувиллын зүгээс сүү худалдан авах үнэд өөрчлөлт оруулж буйг малчдад мэдэгдсэн юм.

2) 2004 оны 6 сарын 21 – нээс 8 сарын 2 хүртэлх Сувиллын газрын үйл ажиллагааны тухай

i) Сувилуулагчдын тухайд

2004 оны зун Бүрдэний сувилал 6 сарын 21-нээс 7 сарын 4 (1-р ээлж), 7 сарын 5 –наас 7 сарын 18 (2-р ээлж), 7 сарын 19-нээс 8 сарын 2 (3-р ээлж) хүртэл 3 ээлжээр нийт 43 хоног ажиллав. Дараахь хүснэгтээс үзэхэд сувилуулагчдын тоо 2003 оныхоос 21 хүнээр нэмэгдэн, нийт 147 болсон (17 %-иар өссөн).

Хүснэгт 4.6.23 Сувилуулагчдын тоо ээлж тус бүрээр

	1-р ээлж	2-р ээлж	3-р ээлж	Нийт	Дундаж.	Нийт хүн/хоног	1 сувилуулагчид ноогдох дундаж хоногийн тоо
2003	52	43	25	120	40.0	1360 өдөр	11.3
2004	38	51	52	141	47.0	1498 өдөр	10.6

Тэрчлэн сувилуулагчдын нийт хүн / хоногийн тоо 10.1 %-иар өсөж 1498 болсон бол нэг амрагчид ноогдох дундаж хоногийн тоо 2003 оныхоос бага зэрэг буурсан байдалтай байна.

ii) Малчдын тухайд


(Сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэлтийн байдал)

Хэдийгээр сумын ЗДТГ- аас сурталчилгааны үйл ажиллагааг идэвхитэй явуулсан боловч малчид Бүрдэний орчимд төсөөлж байсан хэмжээнд нүүж ирсэнгүй. Сувилал нээгдэх үед ердөө 5-аас 6 ингэ сааж, 20-иодхон литр сүү нийлүүлж байв. Сувиллын орчимд малчид нүүж ирээгүй нь 2004 онд Бүрдэний хавьд гандуу, өвс ногооны гарц муу байсан, мөн малчид 6 сарын сүүлээр болсон УИХ-ын сонгууль өнгөртөл холдож нүүхийг хүсээгүй зэрэг 2 гол хүчин зүйлээс шалтгаалсан байлаа.

Анхнаас нь малчдыг бүлгийн зохион байгуулалтад оруулахаар ярьж үзсэн боловч малчид хувийнхаа малыг нэг бүлгийн гишүүн ч гэсэн өөр хүнд даатгахыг хүсэхгүй байсан учраас сүү борлуулах малчдын бүлгийг зохион байгуулж чадаагүй. Угаасаа тэдгээр малчид бүлэг болж үйл ажиллагаа явуулах эрмэлзэл багатай, сувиллын газарт бүтээгдэхүүн борлуулах нэгдмэл зорилтыг биелүүлэх шаардлага малчдад бага байсан нь асуудал болж байлаа. Борлуулалтыг сайжруулахын тулд худалдан авах үнийг нэмэх тухай хэлэлцээрийг малчдаар өөрсдөөр нь хийлгэх зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан хамтын бүлэг гэдэг ухамсрыг төлөвшүүлэх явдал малчдын эрх ашгийн талаас бодоод үзсэн ч ач холбогдолтой гэж санагдана.

2004 оны зун сувилал ажиллах бүхий л хугацаанд Бүрдэнэд гандуу байсан боловч сонгуулийн дараа малчин В хоёр өрхийн 10 гаруй тэмээ авч ирж нэгдсэнээр нийт 17 тэмээ бүхий, сувилалд сүү нийлүүлэх нэгж бүрдэж, өдөрт 30 гаруй литр хоормогийг


тогтвортой нийлүүлэх болов. Зарим өдөр нийлүүлэх хоормогийн хэмжээ 40 литрт хүрч байв. Дараахь зурагт малчин өрхүүдээс ингэний хоормог, ямааны сүү нийлүүлсэн байдлыг ээлж тус бүрээр харуулав.



Зураг 4.6.11 Малчдаас сүүн бүтээгдэхүүн нийлүүлсэн байдал

(Борлуулалтын орлого)

Хоормог худалдан авах үнэ ба сувилуулагчдын хүн/хоногийн тоо өссөн (тус бүр 17.5%, 10.1%-иар өссөн) зэргээс шалтгаалан сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээ нэмэгдсэн тул нийлүүлэлтийн хэмжээ ч нэмэгдэв. Мөн нэг сувилуулагчид ноогдох хоормогийн хэмжээ өнгөрсөн жилийн 0.72 литрээс 0.8 литр болж нэмэгдсэн байна. Үүний үр дүнд ингэний сүү нийлүүлсэн



Зураг 4.6.12 Сүү, сүүн бүтээгдэхүүний борлуулалтаас малчдын олсон орлогын хэмжээ (2004он)
(Эх сурвалж: Эрдэнэ сумын ЗДТГ)

малчин өрхүүдийн бэлэн мөнгөний орлого нэлээд нэмэгдэв. 2004 онд ингэний хоормогийн борлуулалтаас малчдын олсон нийт орлогын хэмжээ өнгөрсөн жилийн 425,893 төгрөгөөс ихээхэн өсөж 756,915 төгрөг (77.7%-иар өссөн) болсон байна.

2004 онд сувилалд сүү нийлүүлсэн 4 өрхийн (Малчин В 2 өрхийн тэмээ авч ирсэн тул хэрэг дээрээ 5 өрх болно) орлогын байдлыг дараахь зурагт харуулав.


Мөн ямааны сүүний борлуулалт ч нэмэгдэж (27.6%), нийт орлогын хэмжээ нь өнгөрсөн жилийн 112,375 төгрөгөөс 143,439 төгрөг болж өссөн байна. Гэвч 1 литр сүүний үнэ 350 төгрөг хэвээрээ байсан болно.

Сувиллын газрын эргэн тойрны бэлчээрт тэмээ идэхэд тохиромжтой ургамал голлон ургадаг таатай нөхцөлтэй бөгөөд сувиллын газарт ингэний сүүний эрэлт хэрэгцээ маш их тул цаашдаа ямаа бус тэмээнийхээ тоо толгойг өсгөхөд анхаарах нь бэлэн мөнгөний орлого олох гэдэг талаасаа зөв зүйтэй арга хэмжээ болно.

Сувиллын газрын хувьд эмчилгээнд хэрэглэх ингэний сүүний нийлүүлэлтийг тогтвортой байлгах явдал байнгын асуудал болж байдаг тул сувиллаас зайтай газраас сүү авчирч борлуулах талаар ч бодож үзэж болох бөгөөд нийлүүлэх сүүний хэмжээг тогтвортой найдвартай байлгана гэсэн нөхцөлтэйгөөр борлуулах үнэндээ тээвэрлэлтийн зардлаа оруулан үнээ дахин нэмэх талаар малчид өөрсдөө сумын ЗДТГ-тай ярилцах бүрэн боломжтой.

(Бэлчээр ашиглалт)

2004 онд Бүрдэний ойр хавьд бэлчээр ашиглалтын байдал ямар байсныг дараахь зурагт харуулав. Дээр өгүүлсэнчлэн хэдийгээр бэлчээрийн байдал сайнгүй байсан ч 5 айл Бүрдэнэд ирж сувилалд сүү, цагаа нийлүүлсэн болно. Гэвч малчид хэдийгээр бэлэн мөнгөний орлогод татагдаж байсан боловч өвөлд бэлдэж малдаа тарга хүч авахуулах шаардлагатай тул 8 сарын эхээр бэлчээр сайтай газар руу нүүсэн байна.



Зураг 4.6.13 Бүрдэний худаг орчмын бэлчээр ашиглалтын байдал

iii) Сувиллын газрын үйл ажиллагаа

(Орлого, зарлагын тайлан)

Бүрдэний сувиллын газрын 2003-2005 онуудын орлого, зарлагын байдлыг доор үзүүлэв. 2003 онд 203, 250 төгрөгийн алдагдалтай ажилласан бол 2004 онд сувиллын үнээ нэмсэний дүнд 247, 530 төгрөгийн ашигтай ажиллаж, 2005 онд

дахин бага зэрэг алдагдалтай ажилласан байна. Цаашид хүнсний хангамжид гарч буй үргүй зардлыг багасгаж үр ашигтай зарцуулах, сүү, сүүн бүтээгдхүүн худалдан авах хангалттай хэмжээний хөрөнгийг нөөцөлж явах зорилтууд тулгарч байна.

Хүснэгт 4.6.24 Бүрдэний сувиллын орлого, зарлагын байдал (2003-2005 он)

Зарлага	Агуулга	2005	2004	2003
Орлого		5,735,800	4,537,100	3,226,900
Сувилуулагчдын төлбөр	3,500төгх40хүнх14 хоногх3 ээлж	5,679,100	4,443,600	3,106,900
Арьс борлуулсан орлого	2,500төгх14хоногх3 ээлж	56,700	93,500	105,000
1 төлөг				15,000
Зарлага		5,761,582	4,289,570	3,430,150
Ингэний хоормог, ямааны сүү	Хоормог 650 төг, ямааны сүү 350 төг, 3 ээлжийн нийлбэр	1,045,350	928,200	538,550
Хүнс	Мах ба бусад хүнсний зүйл	2,896,004	1,385,078	1,399,034
Цалин хөлс	Ус зөөх, аргал түүх, тогооч	405,216	320,000	292,713
	Эмч		42,000	
Байгаль орчин хамгааллын шимтгэл				203,250
Шатахууны зардал		415,850	156,250	200,000
Нийлбэр		4,762,420	2,831,528	2,633,547
Байрны засварын зардал	Гал тогоо засварын материал, аяга таваг, хөшиг, хөнжил, гудас	738,900	898,042	796,603
Нийлбэр		5,501,320	3,729,570	3,430,150
Усны үнэ	Ус цэвэршүүлэгч төхөөрөмжийн хуримтлал	260,262	560,000	0
Ашиг		-25,782	247,530	-203,250

(Өрөмдмөл худгийн усны чанар, ус цэвэршүүлэх төхөөрөмжийн доголдлын тухай)

6-р сарын дундуур судалгааны баг сумын ЗДТГ–тай хамтран цэвэршүүлэх төхөөрөмжийг суурилуулснаас хойш 7 хоног хэртэй ажиллуулсны дараа усан санд хуримтлуулсан ус зэвэрч, цэвэршүүлэх төхөөрөмжийн ус цэвэршүүлэх хэмжээ огцом буурч эхэлсэн тул төхөөрөмжийн ашиглалтыг түр зогсоосон болно. Өрөмдмөл худгийн төмрийн агуулга ихтэй усыг усан санд хуримтлуулсны дараа зуны өндөр температурт исэлдэн зэвэрч, цэвэршүүлэх төхөөрөмжийн шүүлтүүр зэвэнд бөглөрснөөс дээрхи доголдол үүссэн болов уу гэж таамаглаж байлаа. Аз болоход эсрэг нэвтрэлтийн мембрант шүүлтүүр гэмтээгүй байсан бөгөөд туслах шүүрийг сольж тавьснаар доголдлыг арилгав. Гэвч дахин гүний худгийн усыг цэвэршүүлэхэд ашиглах боломжгүй гэж үзсэн тул цэвэршүүлэх төхөөрөмжийг сувиллын ойролцоох гар худгийн дэргэд шинээр худаг гаргаж ашиглахаар болсон юм. Ингээд сумын ЗДТГ – аас яаруу сандруу ухсан (худгийн ажилд төслөөр нийлүүлсэн багаж хэрэгслийг ашигласан) гар худаг болон өмнө нь байсан гар худгийн усыг нийлүүлэн тодорхой хэмжээний усыг цэвэршүүлэх боломжтой болов. Гэвч ус цэвэршүүлэх хэмжээ нь 2 –аас 3 хоногийн дараа дахин багасаж эхэлсэн тул ашиглалтыг зогсоосон байлаа. 9-р сард хийсэн судалгааны явцад ус цэвэршүүлэх төхөөрөмжийн доголдол нь төхөөрөмжийг ажиллуулах үедээ хоолой доторхи хийг сайтар гаргадаггүй байсан болон нарны батерейн цэнэгийг сайтар хуримтлуулдаггүй байснаас болсон гэсэн дүгнэлтэд хүрсэн болно.

3) Сувиллын газрын 2004 оны үйл ажиллагаа дууссаны дараа

(Сувилуулагчдын хандлага)

Сумын ЗДТГ-аас идэвхтэй сурталчилсан цэвэршүүлэх төхөөрөмжөөр цэвэрлэсэн гүний худгийн усыг унданд хэрэглэх найдвар талаар болж, нэг хүнд ноогдох хоормогны хэмжээ ч хангалттай бус байсан боловч үнийн хувьд бусад сувиллаас харьцангуй хямд хэвээр байсан тул үнэ нэмэхэд сувилуулагчдын зүгээс хүчтэй эсэргүүцэл үзүүлээгүй болно.

(Малчдын хандлага)

Сувилалд ингэний хоормог нийлүүлсэн малчид сүү худалдан авах үнэ өссөнөөр өөрсдийнх нь орлого нэмэгдсэнд сэтгэл хангалуун байлаа. Нөгөө талаар зөвхөн ямааны сүү нийлүүлдэг айлуудын хувьд өрсөлдөөн үүсч, нэг айлд ноогдох борлуулалтын хэмжээ буурсанд бага зэрэг сэтгэл дундуур байв. Гэвч 5 айлын аль аль нь ирэх жил ч гэсэн саах мал байвал сүү нийлүүлэх хүсэлтэй буйгаа илэрхийлж байлаа.

(Сувилал болон ЗДТГ-ын хандлага)

Сувилуулагчдын ундны усны хангамж сайжраагүй, байгаль цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан малчид нүүж ирээгүйгээс сувилуулагчдад өгөх хоормогны хэмжээ төлөвлөсөн үзүүлэлтэнд (1 хүнд өдөрт 1.5 литр) хүрээгүй зэргээс тавьсан зорилтууд биелээгүй болно. Гэвч сувилуулагчдын зүгээс онцын гомдол, дургүйцэл илэрхийлээгүй бөгөөд сувиллын үнийг өсгөснөөр орлогын байдал сайжирч, менежментийн чиглэлд шинэ өөрчлөлт гарсанд туйлын сэтгэл хангалуун байгаа юм.

(Бэлчээр ашиглалтын талаас нь аваад үзэхэд)

2004 онд Бүрдэнэд ерөнхийдээ гандуу, бэлчээрийн байдал тийм ч сайнгүй байлаа. Гэвч цөөхөн малтай 5 - хан айл нүүж ирээд сар хагас хиртэй л ашигласан тул дээрх оны хувьд бэлчээрийн талхлагдлын талаар санаа зовох явдалгүй гэж бодож байна. Цаашдаа Бүрдэнэ орчмыг зуд болсон үед нөөц өвөлжөө маягаар хослуулан ашиглах боломжтой тул урт хугацаанд зуны улиралд хязгаартай ашиглаж явахыг бодох нь зүйтэй юм.

4) 2005 оны сувиллын үйл ажиллагаа болон малчдын сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулсан байдал

1) Бүрдэний сувиллын газрын 2005 оны үйл ажиллагаа эхлэх хүртэлх бэлтгэл ажил
Эрдэнэ сумын ЗДТГ-ын харьяа Бүрдэнэ сувиллын газрын хувьд 2005 оны үйл ажиллагаа эхлэх бэлтгэл ажлын хүрээнд шинээр хөрөнгө оруулалт нэмж хийгдээгүй. Гэхдээ өмнөх жил суурилуулсан боловч хангалттай ашиглаж чадаагүй

ус цэвэршүүлэх төхөөрөмжийг 6 сарын эхээр сумын ЗДТГ дээр туршилтаар ажиллуулж дахин шалгасан. Нөгөө талаар төслийн үр шимийг хүртэх ёстой гол хүмүүс болох сувиллын газрын ойр орчны малчдаас ингэний болон ямааны сүү худалдан авах арга хэлбэрийн тухайд сумын ЗДТГ-аас малчидтай ярилцан тэдгээр малчдаас авах сүүний хэмжээг малчдын орлогын байдалтай зохицуулан тогтоох талаар зааварчилга өгсөн болно. Сувилуулагчдын ор хоногийн хөлс ба малчдаас сүү худалдаж авах үнийн хувьд ноднин жил өөрчлөн мөрдсөн үнээрээ явах тухай үндсэн чиглэлийг баримталсан. 2005 оны үйл ажиллагааны байдлыг доор өгүүлэв.

ii) 2005 оны үйл ажиллагаа

(Сувилуулагчдын тоо)

Сувилал нь өмнөх жилтэй адилхан 6 сарын 25-нээс 7 сарын 8 (1-р ээлж), 7 сарын 9-нээс 7 сарын 22 (2-р ээлж), 7 сарын 23-нээс 8 сарын 1 (3-р ээлж) гэсэн 3 ээлжээр 39 хоног үйл ажиллагаа явуулсан. 3-р ээлжийн хувьд малчид зуслангаас нүүж эхэлснээр нийлүүлэгдэх сүүний хэмжээ багассан 11 хоног үйл ажиллагаа явуулсан (нэг ээлж 14 хоног байдаг). Гэвч 1-3-р ээлжээр нийт 174 хүн сувилуулсан нь өнгөрсөн жилтэй харьцуулвал 33 хүнээр нэмэгдэж өнгөрсөн жил ор хоногийн үнээ нэмсэн нь огт сөрөг нөлөө үзүүлээгүй байна.


Хүснэгт 4.6. 25 Сувилуулагчдын тоо(2005)

	1-р ээлж	2-р ээлж	3-р ээлж	Нийт	Дундаж.	Нийт хүн /хоног	1 сувилуулагчид ноогдох хоногийн тоо
2004	38	51	52	141	47.0	1498өдөр	10.6
2005	69	74	31	174	58.0	1960өдөр	11.3

(Малчдын борлуулалтын үзүүлэлт)

2005 онд өмнөх жилээс 1 өрхөөр цөөн 4 өрх сувилалд сүү борлуулсан. Үүний дотор 3 өрх нь өнгөрсөн жилээс 2 жил дараалан сүү нийлүүлсэн.

Саалийн малын тооны хувьд ингэ 17 толгой, ямаа 50 толгой байсан. Сувиллын газар их хэмжээгээр хэрэгтэй болдог ингэний сүүний хувьд сумын захиргаанаас 1 өрх өдөрт 16 литр сүү нийлүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна. Малчдаас сувилалд сүү борлуулсан үзүүлэлтийг ээлж бүрээр дараахь зурагт үзүүлэв.




Зураг 4.6.14 Малчдаас сувилалд нийлүүлсэн сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ

Ингэний сүү нийлүүлсэн 3 өрхийн дотроос малчин Б, малчин Г нар өдөрт дунджаар 12-15литр сүү нийлүүлсэн байхад малчин В-гийн хувьд 2005 онд 2-хон толгой ингэ сааж өдөрт 8 литрээс бага сүү борлуулсан. Малчин А –гийн хувьд тэмээ байхгүй учраас малчид хоорондоо зохицож ямааны сүү нийлүүлж бусад 3 малчин нь ямааны сүү нийлүүлээгүй болно. Ингэж сувилалд сүү нийлүүлэхээс гадна сувилуулж байгаа хүмүүст ааруул,буцалгаа зэрэг сүүн бүтээгдэхүүнийг шууд борлуулж байсан нь малчдын хувьд нэмэлт орлого болж өгсөн.

(Малчдын борлуулалтын орлого)

2003,2004,2005 онуудад сувиллын борлуулалтаас олсон малчдын дундаж орлогыг дараахь зурагт харьцуулан үзүүллээ.



Зураг 4.6.15 Сүү ,сүүн бүтээгдэхүүнээс олсон дундаж орлого

Сүү нийлүүлсэн малчдын бэлэн мөнгөний орлого төсөл эхлэхээс өмнөх 2003 онтой харьцуулбал өссөн байна. Өөрөөр хэлбэл ямааны сүүний хувьд эмчилгээнд бус зөвхөн хүнсэнд хэрэглэдэг, хэрэгцээ хязгаарлагдмал тул нийлүүлэлтэнд нь өөрчлөлт гарсангүй. Гэхдээ 2005 онд дээр өгүүлсэнчлэн малчид хоорондоо харилцан тохиролцож сүү нийлүүлснээр малчин А-гийн орлого өнгөрсөн жилийнхээс нэмэгдсэн.

(Сувиллын газрын 2005 оны үйл ажиллагааны тухай)

Бүрдэний сувиллын орлого, зарлагын байдлыг дээр өгүүлсэн болно.

(Ус цэвэршүүлэх төхөөрөмж)

Өнгөрсөн жилийнхтэй адилаар шинэ, хуучин гар худгийн усыг цэвэршүүлэн хэрэглэсэн. Сувилуулагчдын тоо ихээхэн нэмэгдсэнээр өдөр болгон ус цэвэршүүлэгчийг ажиллуулсан ба хүчин чадлын 30-50%-иар л цэвэрлэж байсан байна. Энэ нь дараах 3 шалтгаантай байж болох юм.

1. Хий авалт сайн хийгдээгүй.
2. Ус бохир байснаас шүүлтүүр санаснаас илүү хурдан бөглөрч байсан.
3. Нарны зайн хураагуурын акумляторын цэнэг дутагдалтай байсан зэрэг болно.

Говийн бүс нутгийн усны чанарыг сайжруулах аргын хувьд төслөөр оруулж ирсэн эсрэг нэвтрэлтийн мембрант шүүлтүүр бүхий ус цэвэршүүлэгч төхөөрөмжийг ашиглахаас өөр арга үгүй байна. Гэхдээ чанар муутай усыг цэвэршүүлэх хүчин чадлынх нь талаарх мэдээлэл бага тул цаашид мэдээллийг үргэлжлүүлэн цуглуулж, бүрдүүлж явах нь чухал.

4.6.4 Сүү, сүүн бүтээгдэхүүн хамтран борлуулах төсөл

(1) Зорилго ба үндсэн чиглэл

Энэ төсөл нь зах зээлийн эдийн засгийн шинэ орчинд мал аж ахуйн бүтээгдэхүүний нэг болох сүү, сүүн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх арга зам ямар байж болохыг эрэлхийлэхийг хичээсэн нэгэн оролдлого юм. Урьд өмнө байсан сүү, цагаан идээ нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоо алга болсноос хойш талын нэг амиа аргацаасан аж ахуй эрхлэн амь зууж байгаа малчдад зохион байгуулалт, тээвэр харилцааны элдэв бэрхшээлийг даван туулж, нүүдлийн амьдралын хэв маягийг хадгалан үлдэхийн хамт зах зээлийн харилцаанд идэвхитэй оролцон сүү, сүүн бүтээгдэхүүнээ өөрсдөө хот суурин газрын хэрэглэгчдэд нийлүүлэх боломжийг олгохыг зорьж байгаа юм.


Гадаад орнуудаас импортолдог сүүн бүтээгдэхүүнүүдэд зах зээл бүрэн эзлэгдсэн юм шиг санагдаж буй ч зай завсрыг нь олоод малчны гэрт хийдэг уламжлалт цагаан идээг хот суурины хэрэглэгчдэд хүргэж чадвал тэдний сонирхлыг татаж, орлого олох бүрэн боломжтой юм. Үүний тулд амархан мууддаг сүү сүүн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх хүртэл хадгалах, малчны гэрээс зах зээлд тээвэрлэн хүргэх арга зам, зохион байгуулалтын асуудлыг шийдэх шаардлагатай юм. Ингээд хүйтний улиралд (11 сараас 4 сар) төмөр замаар зорчин ингэний сүү борлуулдаг малчны бүлэгт дэмжлэг үзүүлэх хэлбэрээр дулааны улиралд (5 сараас 10 сар) зах зээлд сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх арга зам ямар байж болохыг туршилтын судалгааны хүрээнд авч үзэхээр боллоо. Сүү, сүүн бүтээгдэхүүнийг жилийн турш зах зээлд нийлүүлэх арга технологийг бий болгосноор, тогтвортой орлого олж болох 3 дахь эх үүсвэрийг эрэлхийлэх зорилго тавьсан.

Үндсэн чиглэлийг дараах 2 зүйлээр тодорхойлж болно.

1. Малчдын улирлын чанартай бэлчээр ашиглалтын хүрээнд сүү, цагаан идээний үйлдвэрлэл, борлуулалтын арга технологийг бий болгох
2. Зууч наймаачдаар дамжуулалгүй үйлдвэрлэлээс борлуулалт хүртэлх бүх үйл ажиллагааг малчдын бүлэг бие даан явуулдаг болох

(2) Төслийн бүтэц, зохион байгуулалт

Дээр өгүүлсэн чиглэлийг төслийн бүтэц зохион байгуулалт болгон илэрхийлбэл дараахь байдалтай байна.



(3) Төслийн төлөвлөлтийн агуулга

1) Малчдын бүлгийг сонгох үйл ажиллагаа

Эрдэнэ сумын ЗДТГ-аас малчдад хандаж сонирхсон малчид сүү сүүн бүтээгдэхүүн хамтран борлуулах бүлэг байгуулахыг уриалсны дагуу 3 малчдын бүлэг оролцох саналаа илэрхийлсэн бөгөөд 2-оос нь төслийн санал гарч ирсэн. Бүлэг тус бүртэй ярилцлага хийсний дараа хүйтний улирал (11-4 сар) - д сүү, цагаан идээ борлуулах туршлагатай, цаашид жилийн турш нийлүүлэх арга замыг эрэлхийлж буй Дөрвөлж багийн малчин Галсан ахлагчтай 4 өрхөөс бүрдэх бүлгийг сонгосон болно.

2) Малчдын бүлгийн бүрэлдэхүүн ба ажил үүргийн хуваарь

(Бүлгийн бүрэлдэхүүн)

Сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах бүлэг нь Галсан ахлагчтай 4 өрхөөс бүрдэнэ. Улаан-Уулд (сумын төв) борлуулалт хийхэд бүлгийн гишүүд бүгд оролцоно. Харин Замын-Үүдэд хүйтний улиралд сүү борлуулахдаа хамтарч ажилладаг танилуудынхаа дэмжлэгийг авахаар тооцсон.

(Ажил үүргийн хуваарь)

Галсангийн 4 өрхийн 16 хүнээс 10 нь үйлдвэрлэлээс борлуулалт хүртэл бүхий л үйл ажиллагаанд доорх байдлаар тодорхой үүрэгтэй оролцоно.

- Сааль авч, боловсруулах : 6 хүн
- Сумын төв болон 1016-р зөрлөг хүртэл зөөвөрлөх: 2 хүн
- Сумын төв дээр борлуулалт хийх: 2 хүн
- 1016-р зөрлөгөөс Замын -Үүд хүртэл зөөж борлуулах: 4 хүн

3) Борлуулах бүтээгдэхүүн ба борлуулалтын хэмжээ

Галсан ахлагчтай бүлэг нь дулааны улирал буюу 5 сараас 11 сарын хооронд сумын төв болон Замын - Үүдэд 7 хоногт 1 удаа сүү, цагаа борлуулж байхаар төлөвлөсөн. Бүлгийн борлуулахаар төлөвлөж буй сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээг дараахь хүснэгтэд харуулав.

Ингэний сүүг бүтэн жилийн турш борлуулахын зэрэгцээ дулааны улиралд бусад төрлийн сүүн бүтээгдэхүүнийг хослуулан борлуулж явна. Хүйтний улирал буюу 11 сараас 4 сарын хооронд ингэний сүү борлуулж байгаа.

Хүснэгт 4.6.26 Борлуулах бүтээгдэхүүн ба борлуулалтын хэмжээ

Сүү цагаа боловсруулах ба борлуулах цаг үе		Боловсруулах, борлуулах бүтээгдэхүүн	Нэгж үнэ	Боловсруулалт ба борлуулалтын хэмжээ (7 хоногт)	Борлуулалтын орлого (төг) (7 хоногт)
Хүйтний улирал	11 сар~4 сар	Ингэний сүү	800төг/л	30 л	24,000
		Ингэний сүү	600 төг/л	20 л	12,000
Дулааны улирал	5 сар~11 сар	Ааруул (бяслаг)	2,500 төг/кг	3~4 кг	7,500~10,000
		Шар тос	3500 төг/кг	200~300	700~1,050
		Тараг	500 төг/кг	15 кг	7,500
		Өрөм	1,500 төг/ш	1~2ш	10,500
		Шимийн архи	1,500 төг/л	3~4 л	4,500~6,000
		Гүүний айраг	800 төг/л	15~20 л	12,000~16,000

4) Үйлдвэрлэл ба нийлүүлэлтийн бүтэц, зохион байгуулалтын төлөвлөгөө


Галсангийн бүлгийн 4 өрхөөс сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах 3 өрхийн нийт малын тоо болон саалинд хэрэглэх малын тоог 2004 оны 9 сарын байдлаар дараахь хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4.6.27 Галсангийн бүлгийн 3 өрхийн нийт малын тоо 2004 он

	Малын тоо	Эм малын тоо	Саалинд хэрэглэдэг малын тоо
Тэмээ	62	22	10
Адуу	121	21	21
Үхэр	66	26	26
Хонь	160	62	62
Ямаа	310	113	110
Total	689	233	218

(Нийлүүлэх газар ба тээвэрлэх арга)


Улаан уул (сумын төв)-аас 20 км зайтай гар худгийг түшиглэн цагаан идээ үйлдвэрлэх, боловсруулах үйл ажиллагаа явуулна. Нийлүүлэх зах зээлийн хувьд одоогоор Замын Үүд, Улаан уул хоёрыг сонгож аваад байна. Саасан сүү болон бусад цагаан идээг гэртээ хуримтлуулаад тодорхой хэмжээнд хүрмэгц 7 хоногт 1 удаа мотоцикл, тэмээ, морь ашиглан тээвэрлэдэг. Борлуулах маршлут болон тээвэрлэх аргыг дараахь зурагт харуулав.



Зураг 4.6.16 Бүтээгдэхүүн борлуулалтын схем

5) Боловсруулалтаас борлуулалт хүртэл хийгдэх ажлын график

Малчид 7 хоногт 1 удаа, сард 4 удаа борлуулалт хийхээр төлөвлөж борлуулах газар руу зөөх өдөр хүртэл гишүүд хамтран саалиа авч, бүтээгдэхүүнээ боловсруулж бэлдэхээр болсон. Гэхдээ 1 өдөрт авах саалийн хэмжээ хязгаарлагдмал тул тодорхой хэмжээнд хүртэл нь хурааж хадгалан тээвэрлэлтийг үр ашигтай байлгах шаардлагатай. Иймд авсан саалиа хадгалахад нь зориулж цахилгаан бус хөргөгчийг¹ нийлүүлэх ба хуримтлагдсан бүтээгдэхүүнийг Улаан Уул руу явуулж борлуулна. Улаан Уул дахь бүлгийн гишүүний гэрээс борлуулалт хийх тул хөлдөөгч, хөргөгчийг тэнд байрлуулна. Эндээсээ мөн Замын Үүдэд борлуулах бүтээгдэхүүнийг ялган, хөлдөөгөөд авч явж борлуулах юм.



Зураг 4.6.17 Сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах арга

¹Цахилгаан хэрэглэдэггүй хөргөгч нь одоогоор туршилтын шатандаа байгаа боловч хэрвээ ажилласан тохиолдолд нүүдэлч малчдын амьдралыг сайжруулахад ихээхэн тустай зүйл болох юм.

6) Тээвэрлэлтэд анхаарах зүйл

Тээвэрлэлтэд (зөөвөрлөлт) зарцуулах шатахууны үнэ өсөх хандлагатай байгаа тул малчдад орох ашгийн хэмжээг ихэсгэхийн тулд тээвэрлэлтийн тоог цөөн байлгах шаардлагатай. Уг төслийн хувьд тээвэрлэлтийн тоог аль болох цөөн байлгаж, түүнд зарцуулагдах зардлыг багасгах болон бүтээгдэхүүнийг малчны гэрт хадгалах шинэ арга замыг эрэлхийлэн, цахилгаан бус хөргөгчийг туршилтын журмаар суурилуулсан болно.

7) Төслийн орлого, зарлагын тооцоо

Дараахь хүснэгтэд малчны бүлгийн бүтээгдэхүүн борлуулалтын орлого, зарлагын байдал ямар байж болохыг хүйтний (11 сар - 4 сар) ба дулааны (5 сар – 10 сар) улирал тус бүрээр харуулав. Бүлгийн 4 өрхийн нийлбэрээр аваад үзэхэд хүйтний улиралд сар бүр 84,192 төгрөг, дулааны улирлын гүүний айраг гардаг 7, 8 саруудад сар тутам 151,382 төгрөг, бусад саруудад 95,382 төгрөгийн ашиг олох боломжтой гэсэн тооцоо гарч байна.

Хүснэгт 4.6.28 Орлого зарлагын урьдчилсан тооцоо

Замын Үүд рүү зөөнө гэж тооцов.

(Нэгж : сар)

1. Хүйтний улирал (11сар~4сар)

(Нэгж : сар)

Борлуулалтын орлого:

Борлуулах бүтээгдэхүүн	Нэгж үнэ	Хэмжээ	Борлуулалтын орлого:
Ингэний сүү	800 төг/л	120л	96,000
		Нийлбэр	96,000

Зардал:

Зардал	Нэгж үнэ (төг)	Хэдэн удаа	Зардал (төг)
Улаан Уул, гэр хоорондын 2 талын тээвэрлэлтийн зардал (мотоцикл)	952	4	3,808
Улаан Уул, Замын Үүд хоорондын 2 талын тээвэрлэлтийн зардал (төмөр замаар)	2000	4	8,000
		Нийлбэр	11,808

Ашиг:	(төг)
Нийлбэр	84,192

952

2. Дулааны улирал (5сар~11сар)

(Нэгж : сар)

Борлуулалтын орлого:

Борлуулах бүтээгдэхүүн	Борлуулах үнэ	Хэмжээ	Борлуулалтын орлого 1	Борлуулалтын орлого 2
Ингэний сүү	600 төг/л	80л	48,000	48,000
Ааруул	2,500 төг/кг	1кг	35,000	35,000
Шар тос	3500 төг/кг	1кг	3,500	3,500
Тараг	500 төг/кг	60кг	30,000	30,000
Өрөм	1,500 төг/ш	7ш	10,500	10,500
Шимийн архи	1,500 төг/л	14л	21,000	21,000
Айраг(7~8сар)	800 төг/л	70л	56,000	0
		Нийт	204,000	148,000

Зардал:

Зардал	Нэгж үнэ (төг)	Хэдэн удаа	Зардал (төг)
Улаан Уул, гэр хоорондын 2 талын тээвэрлэлтийн зардал(мотоцикл)	2,000	8	16,000
Улаан Уул, Замын Үүд хоорондын 2 талын тээвэрлэлтийн зардал (төмөр замаар)	952	8	7,616
Мотор ажиллуулах (6 цагт 1 удаа)	4,338	4	17,352
Цахилгааны төлбөр (Улаан Уулд хөргөгч ажиллуулна)	263	30	7,890
Ариун цэвэр, эрүүл ахуйн хураамж	470	8	3,760
		Нийт	52,618

Ашиг:	Ашиг 1 (төг)	Ашиг 2 (төг)
Нийт	151,382	95,382

* Ашиг 1 нь 7-8 –р сард борлуулах гүүний айрагны орлогыг багтаасан байна.

* Ашиг 2 нь дулааны улирлын бусад саруудад олох ашиг.

8) Эхний хөрөнгө оруулалт

Дулааны улирал (5-11 сар)-ын сүү, сүүн бүтээгдэхүүний борлуулалт тогтвортой бус байдаг асуудлыг шийдэж, жил тойрон борлуулалт хийдэг тогтолцоо бүхий борлуулалтын арга технологитой болгохын тулд малчдын бүлэгт 4.6.27 дугаар хүснэгтэд үзүүлсэн тоног төхөөрөмжийг нийлүүллээ.

Сүүний найрлага шалгах төхөөрөмжийн хувьд малчид бараг хэрэглэдэггүй тул худалдаж аваагүй. Мөн, малчид анхандаа хөлдөөгчөө гэртээ тавихын тулд бага оврын цахилгаан үүсгүүрийг хэрэгцээт тоног төхөөрөмжийн жагсаалтад оруулан хүсэлт гаргасан байсан боловч хөрөнгө оруулалтын мөнгөн дүн хэт их болж, малчдын буцаан төлөх мөнгөний хэмжээ өсөх, түлш шатахууны үнийн өсөлтөөс цахилгаан үүсгүүрийг ажиллуулах зардал ихсэх, ажиллуулах цаг нь багасах зэрэг сөрөг нөхцөл байдал үүсч болохыг харгалзан үзэж, энэ удаад цахилгаан үүсгүүр нийлүүлээгүй болно. Хөлдөөгч, хөргөгчийг нь сумын төв дэх бүлгийн гишүүний гэрт байрлуулсан ба цахилгаан бус хөргөгчийн хувьд дараа тусад нь аваачиж суурилуулсан болно.

Хүснэгт 4.6.29 Нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн жагсаалт (төг)

	Тодорхойлолт	Нэгж	Тоо	Үнэ
Хөлдөөгч	169л	175,000	1	175,000
Хөргөгч	Бирюса Б-10, 240 л	249,000	1	249,000
Сүү зөөх сав	40 л	48,000	1	48,000
	10 л	9,000	2	18,000
	10 л	13,000	1	13,000
Сүү хадгалах сав	8 л	11,000	1	11,000
	6 л	9,500	2	19,000
	Хөнгөн цагаан	7,000	1	7,000
Хэмжүүр	Хуванцар	1,500	2	3,000
				543,000

9) Малчдын бүлгийн хариуцах зардал

1) Жилийн нийт ашгийн төлөвлөгөө

Сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах малчдын бүлгийн жилийн нийт ашгийн төлөвлөгөөг дараахь хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4.6.30 Сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах малчдын бүлгийн жилийн нийт ашгийн төлөвлөгөө. (төг)

	7 сар 8 сар	5 сар 6 сар 9 сар 10 сар	Хүйтний улирал	Бүлгийн олох нийт ашиг	1 өрхөд ноогдох ашиг
Сарын ашиг (төг)	151,382	95,382	84192		
Хугацаа (сараар)	2	4	6		
Ашгийн хэмжээ (төг)	302,764	381,528	505,152	1,189,444	237,889

ii) Зардал хариуцах байдал

Эхний хөрөнгө оруулалт буюу тоног төхөөрөмжийн зардлыг малчдын бүлэг хариуцах ба Эрдэнэ сумын "Сум хөгжлийн сан"-д 100% (543 мян. төг) буцаан төлнө. Энэ бүлгийн хувьд жилийн нийт ашгийн хэмжээ 1,189,444 төгрөг байх тооцоо гарч байгаа. Гэхдээ зарим жилд гантай байх зэргээр гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр ашгийн хэмжээ багасах явдал гарч болохыг харгалзан буцаан төлөлтийг 3 жилийн хугацаанд бүрэн төлөхөөр төлөвлөсөн.

10) Мониторинг хийхэд анхаарах асуудлууд

Хэдийгээр малчдын бүлэг 2003 оны 11 сараас хүйтний улиралд сүүн бүтээгдэхүүн борлуулах ажлаа эхлээд байгаа ч төслийн эхний хөрөнгө оруулалт нь 2005 оны 5 сард дулааны улиралд сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах ажлыг эхлүүлэх зорилгоор хийгдсэн. Мониторинг хийхдээ өвлийн борлуулалтын байдалтай харьцуулан бүтэн жилийн турш борлуулалт хийхэд малчдын амьдралын түвшинд ямар өөрчлөлт гарч байгааг анхааралтай судлах шаардлагатай юм. Анхаарах ёстой өөр нэг асуудал бол саалийн малын тоо жил жилд өөрчлөгдөж болох явдал юм. Мөн бэлчээрийн байдлаас хамааран сүүний гарц хэлбэлзэж болох юм. Тухайн жилийн бэлчээрийн байдалд тохируулан сааж чадаж байна уу үгүй юу гэдэг ч анхаарах асуудлын нэг мөн. Тэрчлэн ингэний сүүнээс бусад төрлийн сүүг малчид анх удаагаа зохион байгуулалттай борлуулах гэж байгаа. Хот суурин газрын улирлын чанартай хэрэгцээний талаар малчид шуурхай зөв мэдээлэл авч чадаж байгаа эсэхэд мониторинг хийх шаардлагатай. Эцэст нь уламжлалт хүнсний хувьд тодорхой хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүн болох сүү цагаан идээг борлуулахдаа ариун цэвэр, эрүүл ахуйн асуудалд онцгой анхаарч, хэрэглэгчдийн итгэл найдварыг олж авахын төлөө хүчин чармайлт гаргах шаардлагатай юм.

(4) Төслийн биелэлт

1) Бэлчээрийн байдал

2005 онд Эрдэнэ сум өнгөрсөн жилээс үргэлжилсэн маш их гантай байгаагаас малчид өвөлд бэлтгэж бэлчээр даган хол нүүдэллэх зэргээр эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байна. Галсан болон малчдын бүлгийхэн ч 2005 оны зун 2-3 удаа нүүдэл хийсэн ба 8 сард байнга ашигладаг худгаасаа холдож хилийн ойролцоох бэлчээр рүү нүүсэн.

2) Сүү, сүүн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн байдал

Дулааны улирлын нийлүүлэлтийн хувьд 6,7-р саруудад хэрэгжсэн ч бэлчээрийн байдал сайн байгаагүйгээс сүүний гарц багасч өнгөрсөн жилтэй харьцуулбал саасан сүүний хэмжээ багассан. Үүнээс шалтгаалж сүү нийлүүлэлтийн хэмжээ хангалттай бус байснаас Замын-Үүдэд хөлдөөгч ашиглан хөлдөөж сүү нийлүүлэх ажил нэг ч хийгдээгүй. Бүлгийн сүү нийлүүлэлт ганцхан сумын төв байсан ч гантай


байснаас бусад малчид хол нүүсэн нь сумын төвд сүү нийлүүлэлт хязгаарлагдаж зах зээлийн тааламжтай боломжийг олгосон. Сумын төвд сүү, сүүн бүтээгдэхүүн ховор байснаар ингэний сүүний үнэ өмнөх жилийнхээс 50-100 төгрөгөөр нэмэгдэж 800 төгрөгөөр зарагдсан. Анх 7 төрлийн сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх байснаас 2005 онд үүнээс 3 төрлийг нь буюу ингэний сүү, буцалгаа, тараг зарсан байна. Нийлүүлэх сүүний хэмжээ бага байснаас 1-2 хоногт бүрэн зарагдаж байсан. Бас суманд амьдарч байгаа бүлгийн гишүүд худалдан авагчдад аман сурталчилгаа явуулсан.

3) Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн бодит байдал

Сүү, сүүн бүтээгдэхүүний сар тус бүрийн нийлүүлэлтийн болон сарын борлуулалтын хэмжээг харьцуулъя. Бэлчээрийн байдал муудсан 4, 5 сар болон 7 сараас 9 сар гартал нийлүүлэлтийн хэмжээ болон борлуулалтын хэмжээ багассан байна. 6 сард бороо орж бэлчээрийн байдал сайн болсноор нийлүүлэлт ба борлуулалтын хэмжээ нэмэгдэж ирсэн. Мөн ингэ 2 жилд нэг ботголдог ба 2005 онд ботголох ингэний тоо цөөн байсан нь сүү бага нийлүүлэхэд нөлөөлсөн.

Төслийн хувьд дулааны улирлын сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэлтийг нэмэгдүүлэхийг зорьсон ч 2005 оны байдлаар бэлчээр муу байсан тул үр дүнг шалгаж тогтоох боломжгүй байлаа. Бас нийлүүлэлтийн хэмжээ бага байснаас Замын- Үүд рүү хөлдөөж зөөх ажил явагдаагүй ба борлуулалт ч сумын төвөөс хэтэрсэнгүй.

Тэрчлэн борлуулсан сүү, сүүн бүтээгдэхүүнээс ингэний сүүг 800 төг, буцалгааг 1000 төг, таргийг 500 төг буюу тогтсон үнээр нь борлуулж байсан ба улирал ба хэрэгцээний байдлаас шалтгаалж үнэ өөрчлөх оролдлого хийгээгүй.



Зураг 4.6.18 Сүү, сүүн бүтээгдэхүүний борлуулалтын орлого (сараар)

4) Анхны хөрөнгө оруулалтын тоног төхөөрөмжийн ашиглалтын байдал

(Хөлдөөгч, хөргөгч, сав зэрэг)

Энэ жил богино хугацаанд сумын төв рүү нийлүүлэлт хийсэн ба сүүний хэмжээ бага байсан ч нийлүүлэлт 6, 7-р сарын 52 өдрийн хугацаанд 22 удаа хийгдсэн байгаа тул нийлүүлсэн тоног төхөөрөмжийн ашиглалт сайн байсан гэж үзэж байна. Гэвч сүүний гарц бага байснаас болж Замын-Үүд рүү сүү нийлүүлээгүй ба сүүг тийшээгээ хөлдөөж тээвэрлэхийн тулд нийлүүлэгдсэн хөлдөөгчийн хувьд түүнийг жинхэнэ зориулалтаар нь ашиглаж чадсангүй гэж хэлж болно.

(Цахилгаан бус хөргөгч)

Цахилгаан бус хөргөгчийг 6 сарын сүүлээр суурилуулсан. Үүний дараа хэд хэдэн удаа ашиглаж үзсэн ба 7-р сараас хөргөгч доторхи температур өндөр болсноос ашиглахаа больсон. Малчдад хүсэлт гаргаж 7-р сарын 15-25 –ны хооронд өдөрт 3 удаа хөргөгчний доторхи ба гаднах температурын хэмжилт хийлгэхэд хөргөгчний доторхи температур шөнөдөө гэхэд л 23-29 хэм байсныг тэмдэглэсэн байна. 2005 оны зун гантай байснаас Галсангийн бүлэг 8 сараас зуслангаасаа холдож хилийн ойролцоох бэлчээр рүү нүүснээр үүнээс хойш ашиглах боломжгүй болсон байна. Гэвч малчид дараа жил дахин ашиглаж үзэх бодолтой байгаа тул дээрээс нь хучих дулаан нэвтрүүлдэггүй материалыг 9 сард хүргүүлсэн.

5) Сумын хөгжлийн санд буцаан төлөлт хийх төлөвлөгөө

2005 оны 8 сарын 25-ны өдөр сүү, сүүн бүтээгдэхүүн хамтран борлуулах төслийн ахлагч ба Эрдэнэ сумын ЗДТГ-ын хооронд буцаан төлөлтийн төлөвлөгөөг хамтран боловсруулах ажил явагдаж, малчдын бүлгээс тэр өдөртөө эхний удаагийн төлбөрийг төлсөн байна. 2005 оны хувьд бэлчээрийн байдал муу байгаа тул 101,000 төгрөг төлж, үлдсэн 450,000 төгрөгийг 4 хуваан төлөхөөр болсон байна.

Хүснэгт 4.6.31
Сүү, сүүн бүтээгдэхүүн
хамтран борлуулах төслийн
буцаан төлөлтийн төлөвлөгөө

Төлбөр хийх хугацаа	Төлбөрийн мөнгөн дүн
2005/08/25	51,000
2005/10/25	50,000
2006/03/25	100,000
2006/06/25	150,000
2006/10/25	100,000
2006/12/25	100,000
	551,000

6) Санхүүгийн бүртгэл хөтлөх арга барилын талаарх сургалт

2005 оны 9 сарын 25-ны өдөр Эрдэнэ сумын ЗДТГ-ын байранд бүлгийн санхүүгийн тайланг хэрхэн гаргах талаарх сургалтыг зохион байгуулсан. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд 9 сард буюу төсөл эхэлснээс хойш 3 сарын дараа анхны санхүүгийн тайланг гаргахаар тусгасан байсны дагуу уг сургалтыг явуулсан болно. Эрдэнэ сумын ЗДТГ-ын санхүү бүртгэл хариуцсан ажилтан ба төслийн санхүү бүртгэл хариуцагч гишүүнийг оролцуулан санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан. Цаашид 6 сар тутамд сум хөгжлийн санд төлөх буцаан төлөлт хийгдэж дуусах хүртэл 2 тал хамтран тайлан гаргаж байхаар боллоо.

Хүснэгт 4.6.32 2005 оны 7 сарын 1-нээс 9 сарын 15-ныг хүртэлх бүлгийн санхүүгийн тайлан

Зардал	Мөнгөн дүн	Ашиг	Мөнгөн дүн
Тээвэрлэх мотоциклын түлш	36,600	Ингэний сүү	32,000
Хөргөгч, хөлдөөгч ажиллуулах цахилгааны хөлс	8,000	Буцалгаа	20,000
Сум хөгжлийн санд хийх буцаан төлөлт	76,000	Тараг	22,500
Нийт зардал	120,600	Нийт ашиг	74,500
Тухайн хугацааны цэвэр ашиг	-46,100		

7) Засч сайжруулах зүйлс

Сүү, цагаан идээгээ борлуулахыг хүсэх нь малчдын бүлгийн хувьд зүй ёсны зүйл юм. 2005 оны зун гантай байснаас бэлчээр ашиглалт хангалтгүй, сүүний гарц муу байсан боловч цаашид бэлчээрийн гарц сайжирвал борлуулалт хэвийн гольдрилдоо орж явагдах боломжтой гэж үзэж байна. Тэрчлэн бүлгийн үйл ажиллагаа жигдэрч, ашиг орлого дээшилбэл анх төлөвлөж байсан бага оврын цахилгаан үүсгүүрээ өөрсдөө худалдан авч, хөлдөөгчөө хөдөөний гэртээ байрлуулах боломжтой. Гэхдээ мотоциклын тээвэрлэлтийн зардлыг бага байлгах эсвэл хөлдөөгч ажиллуулах цагаа багасгахын тулд бүтээгдэхүүнийг гэрт бага температурыг нь бариулж хадгалах илүү сайн арга технологитой болох явдал зайлшгүй чухал юм.

4.6.5 Хонины ноос боловсруулах, бүтээгдэхүүн борлуулах төсөл

(1) Зорилго ба үндсэн чиглэл

Дорноговь аймагт үйлдвэрийн аргаар гэрийн эсгий үйлдвэрлэх үйл ажиллагааг Алтанширээ болон Өргөн сумдад хэрэгжүүлж байна.

Хүснэгт 4.6.33 Дорноговь аймагт үйл ажиллагаа явуулдаг гэрийн эсгийний үйлдвэрүүд

Сумын нэр	Алтанширээ	Өргөн
Үйл ажиллагаа эрхлэгч байгууллага, хүн	«Шинэ саруул зам» Хоршоо	Хувь хүн
Үйл ажиллагаа эхэлсэн он	1996 он	1999 он
Хөрөнгө	Хоршооны хөрөнгө: 17 сая төгрөг	
Үйлдвэрлэл явуулах хугацаа	Жилд 5 сар	Жилд 3 сар (7-9 сард)
Үйлдвэрлэлийн хэмжээ	Дунджаар 400-500 ширхэг гэрийн эсгий (Дунджаар 11 тонн түүхий эд ашигладаг)	120 ширхэг гэрийн эсгий (480 орчим метр) (Дунджаар 2.5 тонн түүхий эд ашигладаг)
Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж	Хуучнаар ЗХУ-д үйлдвэрлэгдсэн хуучин тоног төхөөрөмж (Эвдрал их гардаг)	Улаанбаатар болон бусад газраас авчирсан хуучин эд анги, сэлбэгийг ашиглан үйлдвэрлэл эрхлэгч өөрөө угсарсан тоног төхөөрөмж
Бүтээгдэхүүний зах зээл	Өөрийн болон зэргэлдээх сумдын малчдад бүтээгдэхүүнээ борлуулдаг	Сумынхаа малчдад бүтээгдэхүүнээ борлуулдаг
Бүтээгдэхүүнээ борлуулдаг газар	Хоршооны дэлгүүрээр борлуулдаг	Үйлдвэр дээрээсээ борлуулдаг (Малчдын гэрээр явж борлуулалт хийдэггүй)
Зээл, бусад санхүүжилт	Авдаггүй	Үйлдвэрлэл явуулах үедээ жилд 1 сая орчим төгрөгийн зээл банкнаас авч ажилладаг Шалтгаан: Бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ 10 сарын үед өсдөг бөгөөд зуны улиралд үндсэндээ борлуулалт хийгддэггүй.


Алтанширээ болон Өргөн сумдаас бусад сумын малчид нь хэрэгцээтэй эсгий бүтээгдэхүүнээ Улаанбаатар, Сайншандаас авах эсвэл өөрсдөө гар аргаар үйлдвэрлэн хэрэглэж байна. Түүнчлэн жижиг эсгий эдлэл (эсгий оймс, малгай, ширдэг г.м.) –ийн тухайд малчид өөрсдийн хэрэгцээнд тохируулан гэрийн нөхцөлд уламжлалт аргаар боловсруулан хийдэг бөгөөд үйлдвэрийн аргаар ийм төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй газар байхгүй байна.

Энэхүү төслийн зорилго нь туршилтын судалгаанд хамрагдах сумдад хонины ноос боловсруулах үйлдвэрлэл үүсгэн байгуулах замаар төсөлд хамрагдаж буй бүлэг болон сумын малчдын бэлэн мөнгөний орлогыг нэмэгдүүлэхэд оршино. Өнөөгийн байдлаар нийт сумын хэмжээнд бэлтгэгдэх хонины ноосны хэмжээ жилд (2003 оны гүйцэтгэлээр) Эрдэнэ суманд 25 тонн, Улаанбадрах суманд 24 тонн, Хөвсгөл суманд 17 тонн-д тус бүр хүрч байгаа хэдий ч, хонины ноосны зах зээлийн үнэ хямд (3 сумын дунджаар: 100-200 төг/кг) байдаг тул малчдын орлогын гол эх үүсвэр болж чаддаггүй. Иймд хонины ноосыг боловсруулж, нэмүү өртөгтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах нь төсөлд хамрагдаж буй иргэдийн бэлэн мөнгөний орлогыг нэмэгдүүлэх боломж олгохын хамт түүхий эд нийлүүлэгч болох сумын малчдын өрхийн амьжиргаа төлөвшин тогтворжих явцад хувь нэмэр оруулах найдвар төрүүлж байна.

Туршилтын төслийн хүрээнд үйлдвэрлэлийн эхний үе шатанд гарах зардлыг санхүүжүүлэх боломжтой хэдий ч, тоног төхөөрөмж авах зэрэгт шаардагдах хөрөнгө оруулалтыг бие даан санхүүжүүлэх бололцоогүй бүлгийг хөнгөлөлттэй нөхцлөөр (урт хугацааны хүүгүй зээл) санхүүжүүлж, үйлдвэрлэлийн арга технологи болон удирдлага менежментийн тал дээр дэмжлэг туслалцаа үзүүлснээр ноос боловсруулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлэх бүлгийн үйл ажиллагаа, зохион байгуулалтыг бүрэлдүүлэн тогтоох бөгөөд үйлдвэрлэл нь тогтвортой хэвийн үйл ажиллагаатай явуулах боломжтой эсэх, ойр орчныхоо малчдад ямар нөлөө үзүүлэх талаар судална.

(2) Төслийн бүтэц, зохион байгуулалт

Дээр өгүүлсэн чиглэлийн дагуу төслийн бүтэц зохион байгуулалтыг схемчлэн үзүүлбэл доорх байдалтай болно.



(3) Төслийн төлөвлөгөөний агуулга

1) Туршилтын төслийн сонгон шалгаруулалт

Судалгаанд хамрагдах сумдын иргэдийн зүгээс боловсруулсан нийт 6 (гэрийн эсгий үйлдвэрлэх: 4 бүлэг, жижиг эсгий эдлэл үйлдвэрлэх: 2 бүлэг) саналыг техник, эдийн засгийн үзүүлэлт, бүтээгдэхүүний зах зээл, үйл ажиллагааны удирдлагын нөхцөл байдал зэрэг хүчин зүйлс тус бүрээр хэрэгжих бодит нөхцөл байдлыг нь судлан дүгнэж, туршилтын судалгааны явцад хэрэгжүүлэх төслүүдийг сонгон шалгаруулсан.

Гэрийн эсгий үйлдвэрлэх талаар 4 бүлгээс гаргасан саналыг 4.6.34 дугаар хүснэгтэд үзүүлсэн бөгөөд энэ нь орон нутгийн малчдын хувьд сонирхол татаж буй үйл ажиллагаа гэдгийг гэрчилж байна. Арга технологийн хувьд тодорхой түвшний сургалт явуулснаар гэрийн эсгий хийх үйлдвэрлэлийн хувьд ч тэр, жижиг эсгий эдлэл хийх үйл ажиллагааны хувьд ч мөн адил сум орон нутагт хэрэгжүүлэх бүрэн бололцоотой юм. Гэсэн хэдий ч, гэрийн эсгий нь овор, жин ихтэй бүтээгдэхүүн бөгөөд тээвэрлэлтийн зардал өндөр байдаг тул, хол газарт тээвэрлэн борлуулах хүндрэлтэй ба бүтээгдэхүүний үндсэн худалдан авагч нь орон нутгийн малчид байдаг. Иймээс ч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ хязгаарлагдмал байна гэж үзэхэд хүргэдэг. Мөн Монгол улсын дотоодын зах зээлээс олдох боломжтой гэрийн эсгий үйлдвэрлэх зориулалтын тоног төхөөрөмж нь хүчин чадал, овор ихтэй ганцхан төрлийн тоног төхөөрөмж байдаг тул энэ нь бага оврын үйлдвэрлэлд тохирдоггүй байна. Ийм бодит нөхцөл байдалд зэргэлдээ байрлах 3 суманд олон тооны гэрийн эсгийний үйлдвэрлэл байгуулах явдал нь бүлгүүд хоорондоо хүчтэй өрсөлдөх тааламжгүй байдлыг үүсгэх магадлалтай байсан тул туршилтын судалгааны хүрээнд байгуулах гэрийн эсгийний үйлдвэрийн тоог нэг болгож буулгасан.

Хүснэгт 4.6.34 Ноос боловсруулах тухай төслийн саналууд

Сумын нэр	Эрдэнэ		Улаанбадрах		Хөвсгөл	
	О.Эрдэнэ-О чир + 7 гишүүн	Р.Энхтуяа + 4 гишүүн	Мөнхнасан + 8 гишүүн	Баянцагаан + 7 гишүүн	О.Одончимэг + 9 гишүүн	Мөнхчимэг + 3 гишүүн
Үйл ажиллагааны чиглэл	Ноос угаах, гэрийн эсгий үйлдвэрлэх (3 тонн ноос боловсруулах, жилд 3 сар үйлдвэрлэл явуулах)	Жижиг эсгий эдлэл хийх (эсгий улавч, оймс, бэлэг дурсгалын зүйлс, малгай г.м.) (245 кг хонины ноос боловсруулах, жилд 7 сар үйлдвэрлэл явуулах)	Гэрийн эсгий үйлдвэрлэх (1 тонн хонины ноос боловсруулан, 40 ширхэг гэрийн эсгий үйлдвэрлэх)	Жижиг эсгий эдлэл хийх (194 кг хонины ноос боловсруулах, бүтэн жилийн турш үйлдвэрлэл явуулах)	Гэрийн эсгий, эсгий гутал үйлдвэрлэх, арьс шир боловсруулах	Гэрийн эсгий, эсгий гутал үйлдвэрлэх (5.5 тонн ноос боловсруулах, жилд 3 сар үйлдвэрлэл явуулах)
Төслийн саналд заасан арга замууд	Хонины ноос угаах үйлдвэр байгуулан ажиллуулах	Малын гаралтай түүхий эдийг ашиглан сдер тутмын хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах.	Хонины ноосоор бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулж, ашиг орлогоо нэмэгдүүлэх.	Орон нутагтаа эсгийний үйлдвэр байгуулж, малчдаас хангалттай өндөр үнээр түүхий эд худалдан авах.	Бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар түүхий эдийн үнийг хангалттай өндөр түвшинд хүргэх. Эргээд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ хямдаар борлуулж, үр ашигтай үйл ажиллагаа явуулах.	Нийт сумын хэмжээнд хонины ноос худалдан авч, дотоодын болон гадаадын зах зээлд борлогдох хонины ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах.

Иймээс хонины ноос боловсруулах, бүтээгдэхүүн борлуулах Эрдэнэ сумын Энхтуяа ахлагчтай (жижиг эсгий эдлэлийн үйлдвэрлэл), Улаанбадрах сумын Баянцагаан ахлагчтай (жижиг эсгий эдлэлийн үйлдвэрлэл) болон Хөвсгөл сумын Мөнхчимэг ахлагчтай (гэрийн эсгий, эсгий гутлын үйлдвэрлэл) бүлгүүдийн саналыг хэрэгжүүлэхээр сонгосон.

Энхтуяа ахлагчтай бүлэг :

Бүлгийн ахлагч Энхтуяа нь багш, захирлаар ажиллаж байсан бөгөөд тэтгэвэрт гарсныхаа дараа сумын ЗДТГазарт сумын иргэдэд зориулсан албан бус сургалтын (ажил, мэргэжлийн сургалт) асуудал хариуцан ажиллаж байна. Төслийн хүрээнд хэрэгжүүлэх хонины ноос боловсруулах үйлдвэрлэлийн тухайд мэргэжлийн сургалтанд хамрагдаж байгаагүй. Бүлгийн бүх гишүүд нь зудын гамшгийн улмаас малгүй болсон төдийгүй өнөөгийн байдлаар ажилгүй байгаа хүмүүс байна. Өрх толгойлсон эмэгтэйчүүд зэрэг тэтгэвэр, ажилгүйдлийн тэтгэмж төдийхнөөр амьдралаа залгуулж буй орлого багатай, эмзэг бүлгийн хүмүүс юм. Энэхүү туршилтын төслөөр дамжуулан одоо ажилгүй байгаа бүлгийн гишүүд нь ноос боловсруулах үйлдвэрлэлийн арга технологид суралцан, цаашид өөрсдийн амьдрал ахуйгаа бие даан авч явах чадвартай болно гэж бүлгийн ахлагч Энхтуяа нь хүсэн найдаж байна.

Баянцагаан ахлагчтай бүлэг

Баянцагаан ахлагчтай бүлэг нь 2003 оны 10 – 11 сард (нийт 2 сарын хугацаанд) ноос самнах болон хатаагч төхөөрөмжүүдийг ашиглан жижиг эсгий эдлэлийг гар аргаар хийж, тус хугацаандаа бүтээгдэхүүний борлуулалтаас 301500 төгрөгийн орлого олсон байна. Туршилтын төслийн хүрээнд 2003 онд ашиглаж байсан тоног төхөөрөмж дээрээ ноос боловсруулах 2 төхөөрөмж шинээр нийлүүлэх бөгөөд ингэснээр үйл ажиллагааны үр өгөөж нь нэмэгдэж, бүтэн жилийн турш үйл ажиллагаа явуулах бололцоотой болох юм. Бүлгийн ахлагч Баянцагаан нь мал эмнэлгийн үйлчилгээний нэгж удирдан ажиллуулахын хамт жижиглэн худалдааны дэлгүүр ажиллуулдаг. Багууд болон зэргэлдээ сумууд руу томилполтоор явах ажил их гардаг, танил хүмүүсийн хүрээ их өргөнтэй. 2003 онд 2 сарын хугацаанд хамтран ажилласан хүмүүс нь туршилтын төсөлд хамрагдах бүлгийн гишүүд болсон ба гишүүдийн хоорондын харилцаа холбоо нягт бүрэлдэн тогтсон, ноос боловсруулах арга технологийн тухайд тодорхой хэмжээний мэдлэг ойлголттой бүлэг юм.

Мөнхчимэг ахлагчтай бүлэг

Хөвсгөл сумын Мөнхчимэг ахлагчтай бүлэг нь гэрийн эсгий үйлдвэрлэн борлуулах үйл ажиллагаа явуулж, үйлдвэрлэлийн түүхий эдээ орон нутгаасаа бэлтгэн нийлүүлэх замаар малчдад хонины ноосоо найдвартай борлуулах боломж олгохын хамт, эргээд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ орон нутгийн иргэдэд бусад газраас ирсэн бараа бүтээгдэхүүнээс хямд үнээр нийлүүлэх төлөвлөгөөтэй байна. Бүлгийн ахлагч Мөнхчимэг нь Улаанбаатар хотод ХААИС-ийг дүүргэж, төрсөн нутагтаа ирж ажиллаж байгаа бөгөөд одоогоор сумын ЗДТГ-т ХАА-н түшмэлийн алба хашиж байна. Тэрээр 23 настай ба сум орон нутгийнхаа хөдөө аж ахуйг хөгжүүлэх талаар идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй нэгэн юм.

2) Шаардагдах үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, тэдгээрийн үнэ

Гэрийн эсгий болон эсгий гутал, жижиг эсгий эдлэл үйлдвэрлэх үйлдвэрлэлд эхний ээлжинд худалдан авах шаардлагатай гол гол тоног төхөөрөмжүүд¹ ба тэдгээрийн үнийг дараахь хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 4.6.35 Хонины ноос боловсруулахад шаардлагатай тоног төхөөрөмж ба тэдгээрийн үнэ

Энхтуяа ахлагчтай бүлэг		Баянцагаан ахлагчтай бүлэг		Мөнхчимэг ахлагчтай бүлэг	
Тоног төхөөрөмжтэй холбоотой зардал	Үнэ (төг)	Тоног төхөөрөмжтэй холбоотой зардал	Үнэ (төг)	Тоног төхөөрөмжтэй холбоотой зардал	Үнэ (төг)
Самнагч төхөөрөмж /гар ажиллагаатай/	300,000	Сэмлэгч төхөөрөмж /гар ажиллагаатай/	500,000	Самнагч төхөөрөмж /цахилгаан/	3,700,00
Сэмлэгч төхөөрөмж /гар ажиллагаатай/	500,000	Утас ээрэгч /гар ажиллагаатай/	220,000	Сэмлэгч төхөөрөмж /цахилгаан/	2,500,00
Утас ээрэгч	220,000	Сам /2 ширхэг/	74,000	Барабан	1,300,00
Сам /5 ширхэг/	185,000	Угсралтын зардал	150,000	Агшаагч төхөөрөмж /катал/	850,00
Угсралтын зардал	150,000	Бусад багаж хэрэгсэл	135,000	Нягтруулагч /молтков/	1,800,00
Байрны засвар	500,000	Тээврийн зардал	100,000	Ус буцалгах бактай зуух	130,00
Бусад багаж хэрэгсэл	279,000			Угсралтын зардал	700,00
Тээврийн зардал	100,000			Байрны засвар	2,000,00
				Бусад багаж хэрэгсэл	354,00
				Тээврийн зардал	556,00
Дүн	2,234,000	Дүн	1,179,000	Дүн	13,890,00

3) Үйлдвэрлэлийн арга технологийг нэвтрүүлэх сургалтын төлөвлөгөө

Төслийг хэрэгжүүлж эхлэх шатанд бүлэг тус бүрийн үйл ажиллагааны чиглэл болон үйлдвэрлэлийн арга технологийн мэдлэгийн түвшинд нь тохируулсан мэргэжлийн сургалт² зохион байгуулна. Ингэснээр төслийн хүрээнд нийлүүлэх тоног төхөөрөмжийг бүрэн хэмжээнд ашиглах бололцоотой болох төдийгүй зах зээл дээр өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөл боломж бүрдэнэ. Бүлэг тус бүрт зориулсан үйлдвэрлэлийн арга технологийн сургалтын төлөвлөгөөг доор үзүүлэв.

¹ Туршилтын судалгаа тул хөрөнгө оруулалтыг үе шаттай хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй байснаас хэрэгцээт тоног төхөөрөмжүүдийг сонгон тогтоосны дараа бүгдийг нь нэг дор авахаас өөр аргагүй болсон.

² Алтанширээ сумын гэрийн эсгийний үйлдвэр ба Улаанбаатар хот дахь ТББ-ын жижиг эсгий эдлэлийн үйлдвэрээр очиж туршлага судалсан ба тоног төхөөрөмж худалдан авах үедээ дээр өгүүлсэн жижиг эсгий эдлэлийн үйлдвэр ба тоног төхөөрөмжийг (гэрийн эсгийний) үйлдвэрлэсэн Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнгээс мэргэжилтэн урьж, хичээл заалгасан.

(Жижиг эсгий эдлэл үйлдвэрлэх арга технологийн сургалтын төлөвлөгөө)

No	Сургалтын агуулга	No	Сургалтын агуулга
1	Хонины ноосны тухай - Ноосны төрөл ангилал - Ноосны бүтэц - Ноосны чанар	5	Жижиг эсгий эдлэл үйлдвэрлэх арга технологи - Жижиг эсгий эдлэлийн төрлүүд, тэдгээрийн эрэлт хэрэгцээ - Хонины ноосоор хийх эсгий эдлэлийн онцлог - Жижиг эсгий эдлэлийн үйлдвэрлэлд шаардагдах багаж төхөөрөмж - Эсгий эдлэл тус бүрийг хийх арга технологи, тэдгээрийн онцлог Улавч / Малгай Жижиг эдлэл / Бээлий
2	Хонины ноос боловсруулах - Ноос ялгах - Угаах, сэмлэх - Самнах - Будах		
3	Эсгий хийх уламжлалт арга технологи	6	Эсгий гутал хийх арга технологи - Эсгий гутал хийхэд шаардагдах багаж төхөөрөмж - Эсгий гутал хийх арга технологи
4	Ноосоор хээ, зураг гаргах		

Тайлбар: Тухайн бүлгийн гишүүдийн мэдлэг чадварын түвшингээс хамааран сургалтын агуулгыг бага зэрэг өөрчлөх боломжтой.

(Гэрийн эсгий болон эсгий гутал үйлдвэрлэх тоног төхөөрөмжийн ашиглалтын арга технологи ба угсралт, суурилуулалтын тухай сургалтын төлөвлөгөө)

No.	Сургалтын агуулга	Хугацаа (өдөр)	No.	Сургалтын агуулга	Хугацаа (өдөр)
1	Эсгийний тоног төхөөрөмжийг угсрах	1	5	Эсгий гутал үйлдвэрлэх арга технологийн тухай сургалт	2
2	Тоног төхөөрөмжийг суурилуулах	1	6	Гэрийн эсгий үйлдвэрлэх арга технологийн тухай сургалт	2
3	Тоног төхөөрөмжийн тохиргоо хийх	0.5	7	Тоног төхөөрөмжинд үзлэг хийж эзэмшигчдэд хүлээлгэн өгөх	2
4	Цахилгааны холболтыг хийх	1			

Тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын ажлыг үйлдвэрлэгч байгууллага болох Хөнгөн үйлдвэрийн Судалгаа, хөгжлийн хүрээлэн хариуцна.

4) Борлуулалтын төлөвлөгөө

Бүлэг тус бүрийн борлуулалтын төлөвлөгөөг 4.6.36 дүгээр хүснэгтэд харуулав.

Жижиг эсгий эдлэлийн борлуулалтын хувьд 1) жижиглэн худалдааны аргаар шууд борлуулах, 2) дэлгүүр, үйлчилгээний байгууллагуудад бөөнөөр нийлүүлэх, 3) дэлгүүр, үйлчилгээний газруудтай гэрээ байгуулан шимтгэл төлж бүтээгдэхүүнээ борлуулах зэрэг борлуулалтын аргуудыг хэрэглэх бололцоотой юм.

Хүснэгт 4.6.36 Борлуулалтын төлөвлөгөө

	Энхтуяа ахлагчтай бүлэг	Баянцагаан ахлагчтай бүлэг	Мөнхчимэг ахлагчтай бүлэг
Эхний жилийн борлуулалтын төлөвлөгөө	Эсгий улавч 105 хос (8,000 төг/хос)	Хүүхдийн эсгий гутал 132 хос (3,500 төг/хос)	178 ширхэг нийт 892 метр урт гэрийн эсгий (борлуулах үнэ 23,000 төг/ш)
	Оймс 105 хос (10,000 төг/хос),	Даллагын уут 144 ширхэг (2,000 төг/ш)	
	Хантааз 56 хос (6,500 төг/хос)	Олбог 24 ш (5,000 төг/ш)	Эсгий гутал 166 хос (11,000 төг/хос)
	Бэлэг дурсгалын зүйлс 105 ширхэг (2,500 төг/ширхэг)	Эсгий оймс 96 хос (1,500 төг/хос)	
	Малгай 105 ширхэг (6,000 төг/ширхэг)	Улавч 108 хос (5,000 төг/хос)	
		Бэлэг дурсгалын зүйлс 156 ширхэг (2,000 төг/ширхэг)	
		Малгай 24 ширхэг (2,000 төг/ширхэг)	
	3,146,500 төг	1,914,000 төг	5,920,000 төг

Ажиллах хугацаа	3 сараас 9 сарыг дуустал 7 сар	Үйлдвэрлэл, борлуулалтыг бүтэн жилийн туршид явуулна.	6-11 саруудад үндсэн үйлдвэрлэл, борлуулалт явуулж, 12, 1 саруудад нэмэлт борлуулалт хийнэ.
Борлуулалт хийх гол газрууд	Сумын төв дэх дэлгүүр	Бүлгийн ахлагчийн эзэмшлийн жижиглэнгийн дэлгүүр	Сумынхаа болон ойролцоо сумын малчдад
	Бүрдэний сувилал	УБ-т музейд	
	Цагаан хөтлийн жуулчны бааз	УБ дахь танилаараа дамжуулан	
	Төмөр зам дагуух суурингийн иргэдэд		

5) Төслийн эдийн засгийн үндэслэл

Бүлэг тус бүрийн зүгээс боловсруулсан үйлдвэрлэл болон борлуулалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн дараахь орлого зардлын тооцоог хийсэн болно.

Хүснэгт 4.6.37 Төслийн орлого зарлагын тооцоо

	Энхтуяа ахлагчтай бүлэг			Баянцагаан ахлагчтай бүлэг			Мөнхчимэг ахлагчтай бүлэг		
	Нэгж үнэ (төг)	Тоо хэмжээ	Үнийн дүн (төг)	Нэгж үнэ (төг)	Тоо хэмжээ	Үнийн дүн (төг)	Нэгж үнэ (төг)	Тоо хэмжээ	Үнийн дүн (төг)
Түүхий эд (хонины ноос)		254кг	19,600		194кг	29,160		1,694кг	507,233
Хурганы ноос								1,997кг	Нийт түүхий эд
Ямааны ноос								249кг	
Үхэр адууны ноос								1,052кг	
Цалин	60,000	4 хүн(1)	1,89,000	20,000	5 хүн хөлслөх	1,200,000	50,000	5 хүн	1,600,000
Ус	1	1,213 л	1,213	1	962 л	962	Зөөх зардал	20 т	5,000
Цахилгаан			39,900			68,400		3000кв/ц	600,000
Бусад материал	1,000	254кг	254,000	1,000	194кг	194,000	Угаалгын нунтаг		22,000
Элэгдэж хорогдох материал							Ороох даавуу, баглах уяа зэрэг		152,500
Хүхэр (эсгий гутал хийхэд хэрэглэх)							1 хос гуталд 80 г		13,280
Тээврийн зардал			100,000			50,000			254,788
Засвар үйлчилгээ		Эхний жилд 1%			Эхний жилд 1%			Эхний жилд 1%	
Байрны түрээс	20,000	12	240,000		Төлөхгүй				120,000
Ус халаах			47,000			72,000			
Үндсэн хөрөнгийн элэгдэл			377,173			210,933			526,567
Нийт зардал			3,058,968			1,886,447			4,215,953
Эхний жилийн орлого			3,146,500			1,914,000			5,920,000
Ашиг			87,532			27,553			1,704,047

6) Бүлгийн зүгээс хариуцах төслийн хөрөнгө оруулалтын хувь хэмжээ

Эрхлэх үйлдвэрлэл, үйл ажиллагаандаа жинхэнэ эзэн ёсоор хандах сэтгэлгээг төлөвшүүлэх зорилгоор, бүлгийн санхүүгийн боломж чадавхийг тооцоолсны үндсэн дээр төслийн өртөг зардлын тодорхой нэг хэсгийг санхүүжүүлэх үүргийг бүлэг тус бүрт хүлээлгэнэ. Бүлгийн зүгээс хариуцан санхүүжүүлэх зардлыг доор дурьдсаны дагуу i) үйл ажиллагааны эхний үе шатанд гарах үйлдвэрлэлийн зардал, ii) хөрөнгө оруулалтын буцаан төлөлт гэсэн хоёр төрөлд хуваан үзнэ.

i) Үйл ажиллагааны эхний үе шатанд гарах зардал

Үйл ажиллагааны эхний үе шатанд гарах зардал гэдэг нь бүтээгдэхүүний борлуулалт жигдрээгүй байх үйлдвэрлэлийн эхний үе шатанд түүхий эд болон бусад материал авах, тээвэрлэлттэй холбогдон гарах зардал зэргийг санхүүжүүлэх зардал хөрөнгө юм. Бүлэг тус бүрээс үйл ажиллагааны эхний шатанд хариуцах зардлыг дараахь хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 4.6.38 Бүлэг тус бүрийн үйл ажиллагааны эхний шатанд хариуцах зардал

Ахлагчийн нэр	Энхтуяа	Баянцагаан	Мөнхчимэг
Хариуцах зардал	60,000 төгрөг, гаднаас авах болон өөрсдийн нийлүүлэх түүхий эд	100,000 төгрөг (2003 онд явуулсан үйл ажиллагааны ашгаас зарцуулна), гаднаас авах болон өөрсдийн нийлүүлэх түүхий эд	1,000,000 төгрөг, гаднаас авах болон өөрсдийн нийлүүлэх түүхий эд

Мөнхчимэг ахлагчтай бүлгийн хариуцах зардлын хэмжээ өндөр байгаа нь эсгий үйлдвэрлэлийн нэг онцлог гэж тайлбарлаж болох бөгөөд шалтгаан нь хүйтний улиралд ашиглагдах гэрийн эсгийний эрэлт хэрэгцээ өсч борлуулалт идэвхтэй явагдах (10-р сараас хойшхи) үе хүртэл гарах түүхий эдийн худалдан авалт, цахилгаан, тээвэрлэлтийн зардал зэргийг санхүүжүүлэх шаардлагатай байдагт оршино.

ii) Хөрөнгө оруулалтын буцаан төлөлт

Дээр дурьдсан үйл ажиллагааны эхний үе шатанд гарах зардлыг хариуцах үүрэг хүлээхээс гадна бүлэг тус бүр нь төслийн анхны хөрөнгө оруулалтын тодорхой нэг хэсгийг (50~80%) эрхлэн явуулах үйл ажиллагаанаас орох ашгаас буцаан төлнө. Бүлэг тус бүрийн хариуцах буцаан төлөлтийн хувь хэмжээг анхны хөрөнгө оруулалтын буцаан төлөлтийг төлж барагдуулсаны дараа бүлгийн хөрөнгөөр эсвэл банк зэрэг санхүүгийн байгууллагуудаас зээл авч тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг хийх чадвартай байхыг урьтал болгон авч үзэв.

Хүснэгт 4.6.39 Бүлэг тус бүрийн хариуцах хөрөнгө оруулалтын буцаан төлөлтийн хэмжээ

Ахлагчийн нэр	Энхтуяа	Баянцагаан	Мөнхчимэг
Хөрөнгө оруулалтын буцаан төлөх хувь хэмжээ, нөхцөл	Буцаан төлөлтийн нийт хэмжээ: 1,790,000 төгрөг (Нийт хөрөнгө оруулалтын 80%) Буцаан төлөлт хийх хугацаа: үйл ажиллагааны 2 дахь жилээс эхлэн нийт 5 жилийн хугацаанд Тооцох хүү: байхгүй	Буцаан төлөлтийн нийт хэмжээ: 940,000 төгрөг (Нийт хөрөнгө оруулалтын 80%) Буцаан төлөлт хийх хугацаа: үйл ажиллагааны 2 дахь жилээс эхлэн нийт 5 жилийн хугацаанд Тооцох хүү: байхгүй	Буцаан төлөлтийн нийт хэмжээ: 6,944,000 төгрөг (Нийт хөрөнгө оруулалтын 50%) Буцаан төлөлт хийх хугацаа: үйл ажиллагааны 2 дахь жилээс эхлэн нийт 7 жилийн хугацаанд Тооцох хүү: байхгүй
Буцаан төлөгдсөн хөрөнгийг байршуулах сан	Улаан Уул сан	Сумын хөгжлийн сан	Сумын хөгжлийн сан

iii) Санамж бичиг (гэрээ) үйлдсэн тухай

Борлуулалт ба буцаан төлөлтийн төлөвлөгөөний талаар бүлгүүдийн ахлагч нартай удаа дараа зөвлөлдсөний үндсэн дээр буцаан төлөх мөнгөний хэмжээг эцсийн байдлаар тодруулж, буцаан төлөлтийн график төлөвлөгөөг хавсаргасан төсөл эхлүүлэх тухай санамж бичиг (гэрээ) (Хавсралт М-ийг үзнэ үү)-ийг сумын ЗД, бүлгийн ахлагч, судалгааны баг 3-ын хооронд байгуулсан.

7) Мониторингийн явцад анхаарах асуудлууд

Бүлэг тус бүрийн хөтлөх бүртгэл тэмдэглэл болон судалгааны багийн авах мэдээлэлд үндэслэн үйлдвэрлэлийн болон борлуулалтын үйл ажиллагаа, ашиг орлогын биелэлт зэргийг тодорхойлно. Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн үйл ажиллагааны үр дүнг судлан, гүйцэтгэл болон төлөвлөгөө нь зөрүүтэй байх тохиолдолд хэрэгжүүлэх зохистой арга хэмжээ авч, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулах тогтолцоо зохион байгуулалтанд эргүүлэн оруулах шаардлагатай юм.

i) Хонины ноос боловсруулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх

Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тухайд бүлгийн хөтлөх бүртгэл тэмдэглэл болон судалгааны багийн авах мэдээллээс дараах үндсэн 3 асуудлыг голлон анхаарч мониторинг хийнэ. Үүнд:

- Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх тогтвортой үйлдвэрлэл
- Үйлдвэрлэлийн арга технологи, мэдлэгийн түвшинг дээшлүүлэх замаар бүтээгдэхүүний чанарын түвшинг хянан удирдах
- Бүтээгдэхүүнийг эрэлт хэрэгцээнд тохируулан үйлдвэрлэх

ii) Хонины ноосон бүтээгдэхүүн борлуулах

Борлуулалтын үйл ажиллагааны тухайд, бүлгийн үйл ажиллагааны бүртгэл тэмдэглэл болон судалгааны багийн авах мэдээлэлд үндэслэн дараахь 4 асуудалд анхаарлаа хандуулан мониторинг хийнэ. Үүнд:

- Төлөвлөгөөний дагуу явуулах борлуулалтын үйл ажиллагаа
- Оновчтой үнийн бодлого
- Хэрэглэгчдийн хүсэлт, хэрэгцээг тодорхойлох
- Зээлээр борлуулалт хийх аргын эдийн засгийн нөлөө

iii) Үйл ажиллагааны ашиг

Үйл ажиллагааны ашигт байдлын тухайд, өмнө дурьдсан үйл ажиллагааны орлого зарлагын дүнг нэгтгэн, төлөвлөсөн хэмжээний ашигтай ажилласан эсэхэд үнэлгээ өгнө. Ялангуяа зардлын гүйцэтгэлийг төлөвлөсөн хэмжээнд байлгасан эсэхийг

нарийвчлан судалж, зардлыг ямагт хэмнэх, бууруулах тал дээр анхаарал тавьж ажиллах нь чухал юм.

iv) Сумын хөгжлийн болон Улаан Уул сангуудад орох хөрөнгө оруулалтын буцаан төлөлт

Бүлгийн үйл ажиллагааны ашгаас Сумын хөгжлийн болон Улаан Уул санд оруулах төслийн хөрөнгө оруулалтын буцаан төлөлт нь төлөвлөгөө хуваарийн дагуу явагдаж байгаа эсэхийг шалгах.

v) Төсөлд хамрагдах бүлгүүдийн бэлэн мөнгөний орлого

Судалгааны багийн авах мэдээлэлд үндэслэн, бүлгийн гишүүдийн бэлэн мөнгөний орлого нэмэгдсэн эсэх зэрэг төсөл хэрэгжүүлснээр гишүүдэд ямар нөлөө үзүүлснийг судална.

vi) Малчдад үзүүлэх нөлөөлөл, үйлчилгээ

Бүлгийн зүгээс хөтлөх бүртгэл тэмдэглэл болон судалгааны багийн авах мэдээлэлд үндэслэн, нутгийн малчдаас үйлдвэрлэлд нийлүүлсэн хонины ноосны хэмжээ болон үнийг судалж, төсөл хэрэгжсэнээр ойр орчмын малчдад үзүүлсэн үр нөлөөллийг тодорхойлно.

(4) Хонины ноос боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслийн биелэлтийн байдал

1) 2004 оны үйл ажиллагааны биелэлтийн байдал

Ноос боловсруулах төслийн хувьд 2004 оны 7-р сард тоног төхөөрөмжийн хуваарилалт болон сургалт дуусаж үйлдвэрлэл эхэлсэн. Бүлэг тус бүр төлөвлөгөөтэйгээ харьцуулахад бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба борлуулалт буурсан боловч түүний хэмжээгээр зардлаа багасгаж чадаагүйн улмаас орлого, зарлагын тэнцэл алдагдаж байна.

Хүснэгт 4.6.40 Хонины ноос боловсруулах, бүтээгдэхүүн борлуулах бүлгүүдийн үйл ажиллагааны байдал (2004 оны 12 сарын байдлаар)

	Эрдэнэ сумын бүлэг	Улаанбадрах сумын бүлэг	Хөвсгөл сумын бүлэг
Бүлгийн гишүүд	Одоогоор 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. 4 гишүүн бүлгээс гарсан. (Шалтгаан: өвчтэй, тоосны аллерги өгсөн зэрэг). Борлуулалт тогтворжихгүй байгаа тул цагаар ажиллах ажилчин авч гишүүдийнхээ тоог өсгөхөөр бодож байна.	Төсөл эхлэхэд 8 гишүүнтэй байсан. Тэдний 3 нь голчлон бүтээгдэхүүнээ үйлдвэрлэдэг байсан ба 1 нь ар гэрийн нөхцөл байдал зэргээс шалтгаалан сүүлийн үед ажиллахгүй байгаа. Мөн анхны гишүүдийн 5 нь бүлгээс гарсан байна. 10-р сарын дундаас шинээр 4 хүн гишүүнээр элссэн ба хуучин гишүүд нь тэдэнд үйлдвэрлэлийн арга технологийг зааж сургаж байгаа боловч шинэ гишүүд одоогоор хамгийн амархан ажлуудыг л хийж чадаж байна.	Одоогоор 5 гишүүнтэй үйлдвэрлэлээ явуулж байна. Анх төслийн санал гаргах үеийн гишүүд ахлагчаас бусад нь бүгд өөрчлөгдсөн боловч үйл ажиллагаа эхлэх үед шинээр орсон гишүүд өөрчлөгдөөгүй ажиллаж байна. Тэдгээр гишүүдийн 2 нь өвлийн улиралд сумын галч хийдэг тул тэр үеэр бүлэгтээ ажиллаж чадахгүй.

Үйлдвэрлэл	Орон нутгийн ноос 190 кг худалдан авч 100 кг орчмыг нь боловсруулж жижиг эдлэл үйлдвэрлэсэн. 11 сар хүртэлх хугацаанд 20 төрлийн ноосон эдлэлийг 150 ширхэг үйлдвэрлэсэн боловч бүлгийн гишүүдийн тоо цөөрснөөс үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо бага байна. Өалийн улиралд үйлдвэрлэлийнхээ хэмжээг багасган үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх төлөвлөгөөтэй.	Сум дотроосоо 130 кг түүхий эд худалдан авч 70 кг-ийг нь үйлдвэрлэлд ашигласан. Нутгийн хонины ноос нь хатуу, бүдүүн ширхэгтэй учир нарийн зөөлөн ноосыг (1 кг нь 8000 төг) УБ-с худалдан авсан бөгөөд энэ нь үнэтэй, олдоц муутайгаас худалдаж авахад хүндрэлтэй байдаг. Чанар сайтай бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд сайн чанарын ноос худалдан авах хэрэгтэй боловч ийм ноос худалдан авах нь ихээхэн хүндрэлтэй байдаг байна. Одоогоор сумын ард иргэдээс бүтээгдэхүүний захиалга авч байгаа боловч гол 2 гишүүн нь ажиллахгүй байгаа учир захиалгыг хурдан хийж өгч чадахгүй байна. Үйлдвэрлэлээ жилийн турш явуулах төлөвлөгөөтэй.	Нутгийн малчдаас 2,5 тонн түүхий эдийг 320 мян. төгрөгөөр худалдан авч 1,3 тонныг үйлдвэрлэлд хэрэглэсэн. Тоног төхөөрөмжид авдрал гарсан боловч өөрсдөө засаж, үйлдвэрлэлээ үргэлжлүүлсэн. Хөвсгөл суманд дизель хөдөлгүүрээр цахилгаан өгдөг хугацаа нь оройн 20-23 цагийн хооронд байдаг. 43ш гэрийн эсгий үйлдвэрлэсэн ба эсгий гутлын үйлдвэрлэлийг дараа хавраас эхлүүлэхээр төлөвлөж байна. 10 сарын 3-наас энэ жилийнхээ үйлдвэрлэлийг зогсоосон.
Борлуулалт	9 сарыг хүртэлх хугацаанд зөвхөн сум дотроо борлуулалт хийж байсан ба 10 сараас хойш Сайншандын зочид буудал ба бэлэг дурсгалын дэлгүүрээр нэмж борлуулалт хийх болсон. 11 сарыг хүртэлх борлуулалтын нийт орлого 250,000 төг орчим. Одоогоор бүтээгдэхүүний чанар тийм сайнгүй тул доогуур үнээр худалдаалж байгаа. Хойшид бүтээгдэхүүнийхээ өнгө үзэмж, чанарыг улам бүр сайжруулан борлуулах үнээ ч бага багаар өсгөж явах төлөвлөгөөтэй.	Сумын хэмжээнд хийж буй борлуулалтаас гадна Сайншанд, Улаанбаатарын бэлэг дурсгалын дэлгүүрүүдэд ч бүтээгдэхүүнээ борлуулж байна. 11 сар хүртэлх хугацаанд 270 орчим мян.төг-ний борлуулалт хийсэн байна. Сайншанд болон УБ дахь итгэмлэсэн борлуулалт хийдэг газруудаас борлуулалт ба барааны үлдэгдлийн мэдээг байнга авч чаддаггүй учир бараа нь дуусчихсан байх үе байдаг. Шинэлэг бүтээгдэхүүн хийх сонирхолтой байгаа боловч технологи, арга барилаа улам бүр сайжруулах шаардлагатай байна.	Энэ жил үйлдвэрлэсэн эсгийгээ сум дотроо болон зэргэлдээх сумдын малчдад бүгдийг нь зарсан. Захиалгаа бүрэн хийж өгч чадахгүй байдалтай байна. Борлуулалтын орлого 1,030,000 төг.

Хүснэгт 4.6.41 Ноос боловсруулах, бүтээгдэхүүн борлуулах төсөлтэй холбогдсон асуудлууд болон авах арга хэмжээ

Ноос боловсруулалт, бүтээгдэхүүн борлуулалттай холбоотой асуудлууд	Арга хэмжээ
1. Эрдэнэ, Улаанбадрах сумд (Жижиг эдлэл)	
<p>1. Борлуулагчид хангалтгүй</p> <p>2. Хөрөнгө оруулсан төхөөрөмжүүдээс утас ээрэх машин ашиглагдаагүй байгаа.</p> <p>3. Бүлгийн гишүүдийн тоо цөөрсөн (үйлдвэрлэлийн хэмжээ бага)</p> <p>4. Борлуулагч бүтээгдэхүүний нөөцгүй болох</p>	<p>1. 10-р сараас Сайншандын гадаадынхан их буудаг зочид буудалд бүтээгдэхүүнийг итгэмжлэгдсэн борлуулагчаар дамжуулан борлуулах ажлыг (орлогын 10%-ийг шимтгэлд төлнө) эхэлсэн. Мөн 11 сараас Сайншандын бэлэг дурсгалын дэлгүүр болон төрөл бүрийн барааны дэлгүүрт итгэмжлэгдсэн борлуулагчтай болж, борлуулалтыг эхэлсэн. Цаашид зах зээлийг тасралтгүй өргөтгөхөд чиглэсэн хэлэлцээрийг бүлэг бүр хэрэгжүүлэх</p> <p>2. 10-р сарын сүүлээр тоног төхөөрөмжийг үр дүнтэй ашиглах болон бүтээгдэхүүний чанарыг сайжруулахын тулд мэргэжлийн хүнээр нэмэлт сургалт явуулсан.</p> <p>3. Хагас цагаар ажиллах гишүүд авч (төлөвлөж буй) хэрэгцээний дагуу ажиллуулна. Ашиглах үед тоос их босгодог ноос самнах машиныг гадаа тавьж ашиглах зэргээр ажлын байрны орчинд санаа тавих.</p> <p>4. Бүтээгдэхүүний нөөцийн талаарх мэдээлэл олж авах арга хэмжээг тогтмол авч, бүтээгдэхүүнээр хэрэгцээтэй үед нь хангах. Мөн нэг удаагийн хангалтын бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх</p>
2. Хөвсгөл сумын бүлэг (гэрийн эсгий)	
<p>1. Төлөвлөсөнтэй харьцуулахад цахилгааны төлбөр маш өндөр.</p> <p>2. Хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн төхөөрөмжүүдээс эсгий гутал хийх зориулалтын машин ашиглагдаагүй.</p> <p>3. Гэрийн эсгий эрэлт хэрэгцээ ихтэй, үйлдвэрлэл нь захиалгаа гүйцэхгүй байгаа</p>	<p>1. Тоолуурын утсыг дутуу холбосноос цахилгааны төлбөр их гарсан. Зассан.</p> <p>2. Гэрийн эсгийний борлуулалт сайн байсан тул эсгий гутал үйлдвэрлэх цаг зав байхгүй байсан. Ирэх хавраас эсгий гутал үйлдвэрлэж эхлэх төлөвлөгөөтэй.</p> <p>3. Цахилгаан түгээх хугацааг үр ашигтай ашиглан үйлдвэрлэвч ажиллуулах. Ажилчдын ажил үүргийн хуваарийг тодорхой болгох</p>

2) 2005 оны үйл ажиллагааны биелэлт

Энэхүү хонины ноос боловсруулах төсөл нь 2004 оны 7-р сараас хэрэгжиж эхэлснээс хойших 1 жил гаруйн хугацаанд мониторинг хийгдэж ирсэн бөгөөд энэ хугацаанд явагдаж ирсэн үйл ажиллагааны бодит байдлын тоо баримт (биелэлт) нь анхны боловсруулсан төлөвлөгөөнөөс зөрүүтэй байна.

1) Энхтуяа ахлагчтай бүлэг

(Анх боловсруулсан төлөвлөгөө ба үйл ажиллагааны биелэлт)

Энхтуяа ахлагчтай бүлгийн үйл ажиллагааны биелэлт ба анх боловсруулсан төлөвлөгөөг 4.6.42 - 4.6.44 дугаар хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 4.6.42 Үйл ажиллагааны биелэлт ба төлөвлөлт (жилээр)

Бүтээгдэхүүний нэр	Үйлдвэрлэх тоо			Борлогдсон тоо	Борлуулалтын орлого (төг)		
	Биелэлт	Төлөвлөгөө	Төлөвлөгөөтэй харьцуулахад (%)		Биелэлт	Төлөвлөгөө	Төлөвлөгөөтэй харьцуулахад (%)
Шаахай	37	105	(35.1)	17	75857	840000	(9.0)
Оймс	27	105	(25.3)	27	52714	1050000	(5.0)
Хантааз	3	56	(4.6)	3	11571	364000	(3.2)
Бэлэг дурсгал	30	105	(28.6)	16	8829	262500	(3.4)
Малгай	3	105	(2.4)	1	4286	630000	(0.7)
Ширмэл ширдэг	9			0			
Даллагын уут	2			1	1286		
Гутлын улавч	14			11	4543		
Хүүхдийн бойтог	25			15	35143		
Бүс	9			9	37714		
Ноосон хөнжил	1			0			
Бээлий	9			3	6000		
Аяганы тавиур	3			3	1800		
Дүн	170	476	(35.7)	105	239743	3146500	(7.6)

*2005 оны 8 сар хүртэлх тоо баримтыг ашиглан тооцоолов.

Хүснэгт 4.6.44. Зардал төлөвлөлт ба бодит зардал (жилээр) (төг, %)

	Бодит зардал	Төлөвлөлт	Бодит зардлыг төлөвлөгөөтэй харьцуулсан нь (%)
Ноос худалдан авах	156120	264600	(59.0)
Цалин	118157	1890000	(6.3)
Ус	4114	1213	(339.3)
Цахилгаан	699	39900	(1.8)
Бусад зардал	37543	147000	(25.5)
Засвар арчлалт	0	22340	(0.0)
Дүн	316633	2027188	(15.6)

* 2005 оны 8 сар хүртэлх тоо баримтыг ашиглан тооцоолов.

Хүснэгт 4.6.43

Орлого зарлагын тэнцэл (жилээр)

	(төг)
Орлого	239,743
Зарлага	316,633
Ашиг	-83,747

* 2005 оны 8 сар хүртэлх тоо баримтыг ашиглан тооцоолов.

Үйлдвэрлэл ба борлуулалт аль аль нь төлөвлөснөөс маш доогуур байна. Үйлдвэрлэл нь төлөвлөсний 36%-д, борлуулалт бүр бага дөнгөж 7%-д хүрч байна. Иймд зарлагдаагүй их хэмжээний бүтээгдэхүүн үлдэж байна.

Зардлын хувьд уснаас бусад бүх төрлийн зардлууд төлөвлөснөөс доогуур байгаа боловч ноос худалдаж авахаар төлөвлөсөн зардлын хувь хэмжээ нь бүтээгдэхүүн

Үйлдвэрлэлийн төлөвлөгөөний хувь хэмжээнээс их байна. Цалингийн хувьд анх төлөвлөж байснаас маш бага цалин олгогдож байна.

Орлого, зарлагын тэнцлийн хувьд одоогоор алдагдалтай ажиллаж байна. 2005 оны 9 сарын 8-ны өдрийн байдлаар 153,500 төгрөгний бүтээгдэхүүн зарагдаагүй үлдсэн байдалтай байлаа. Энэ үлдэгдлийг орлогод хамааруулаагүй болно.

(Төлөвлөгөө биелэгдэхгүйд хүргэсэн хүчин зүйл ба залруулах арга зам)

■ **Үйлдвэрлэл**

Үйлдвэрлэлийн хэмжээ илт бага байгаа шалтгаан нь бүрэн бус бүрэлдэхүүнээр ажиллаж ирсэнтэй холбоотой.

Бас нэг шалтгаан байгаа нь хүн хүч бага хэрнээ бүтээгдэхүүний нэр төрөл олон байгаа явдал юм.

■ **Борлуулалт ба түүнээс олох орлого**

Үйлдвэрлэл нь борлуулалт ба түүнээс олох орлоготой уялдаж өгөхгүй байгаа нь дараах 2 шалтгаантай байна. Үүнд 1: урьд дурдсанчилан үйлдвэрлэх ба борлуулах улирал хоорондоо зөрдөг явдал (Зураг 4.6.19). 2 дахь шалтгаан нь бүтээгдэхүүн ба түүний чанар, үнэ гэсэн үзүүлэлтүүд худалдан авагчдын эрэлт хэрэгцээтэй нийцэхгүй байгаа явдал юм.



Зураг 4.6.19. Хонины ноосон бүтээгдэхүүний борлуулалтын орлого, сараар

■ **Зардал**

Зардлын хувьд цалин анх төлөвлөж байснаас бага олгогдож байгаа. Үүний учир нь гишүүдийн тоо анх байснаас маш цөөрч, цалинг хийснээр, дор дор нь олгож байгаагаас тэр юм.

Түүхий эдийн зардал өссөн нь хонины ноосны чанараас шалтгаалж байна. Сумандаа худалдан авдаг ноос хатуу, чанар муу байдаг. Үүнээс үүдэн 2 асуудал гарч ирдэг. 1-рт, бүтээгдэхүүнээ Улаанбаатарт борлуулъя гэхэд чанарын хувьд гологдох нь олон. Иймд энэ бүлэг хонины ноосныхоо зарим хэсэгт Улаанбаатараас өндөр үнэтэй, чанар сайтай ноос худалдан авдаг болоод байгаа. 2-рт, хөрөнгө оруулалтаар олгогдсон сэмлэгч машины голд ноос орооцолдох нь их байдаг тул намарт авдаг ахрын ноос аль болох

худалдан авч байгаа ба энэ нь уртын ноосноосоо илүү үнэтэй (кг нь 500 төг) байдаг байна.

(Өмнөх үнэлгээний үед тулгарч байсан асуудлууд ба авсан арга хэмжээ)

- Үйлдвэрлэлийг эрчимжүүлэх болон бүлгийн гишүүдийг нөхөн бүрдүүлэх
Цалинг хийснээр олгодог тул хүн олж ажиллуулахад хүндрэлтэй байгаа боловч ахлагч Энхтуяа 2-ын зэрэг хүн яаралтай олж ажиллуулах бодолтой байна.

- Зах зээлээ өргөтгөх

Зах зээлээ өргөтгөхөөр идэвхитэй ажиллаж байна. Одоогоор сумын төв, Сайншанд, Улаанбаатарын зах дээр борлуулалт хийж байна. Сайншанд хотод музейн дэлгүүрээр дамжуулан бүтээгдэхүүнээ борлуулж байгаа. Энэ жилээс Замын-Үүд болон олон улсын галт тэрэг ирж зогсдог Цагаан хад дахь жуулчны бааз зэрэг газруудад бүтээгдэхүүнээ борлуулж үбүеүй.

Хүснэгт 4.6.45

Борлуулалт хийгдсэн газар тус бүр дээрх үзүүлэлт (2005 оны 8 сар хүртэл)
(төг, %)

Сумын төв	176700	63
Сайншанд	36000	13
Бусад	67000	24
Дүн	279700	100

* 2005 оны 8 сар хүртэлх борлуулалтын тоо баримт

- Худалдан авагчдын эрэлт хэрэгцээг мэдэх

Уг бүлгийнхэн сурах судлах эрмэлзэл сайтай, хонины ноосоор жижиг эдлэл үйлдвэрлэдэг адил төстэй газруудад очиж туршлага судлан, тэндээс сурснаа бүтээгдэхүүн хийхдээ хэрэгжүүлж байна. Мөн сумын төвийн худалдан авагчдыг татах талаар ажиллаж, шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд анхаардаг байна.

- Үнэ тогтоох

Өнгөрсөн нэг жилийн туршид цуглуулсан бодит тоо баримтад үндэслэн бүтээгдэхүүн нэг бүрийг үйлдвэрлэхэд зарцуулагдсан зардлыг тооцоолж түүн дээрээ үндэслэн үнэ тогтоож байна. Ихэнх бүтээгдэхүүний хувьд үнэ зөв тогтоон ажиллаж байгаа боловч зарим бүтээгдэхүүний үнийг тохиромжгүй тогтоосин явдал байна.

- Улирлын эрэлт, хэрэгцээнд таарсан үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагааны төлөвлөгөө зохиох

Өвөл ажиллахад ажлын байраа зуух галлаж халаах хэрэгтэй бөгөөд үүнд түлээ, түлшний зардал их ордог гэсэн тул ийм төрлийн зардал бага гаргахын тулд өвлийн улиралд ажлуудаа гэр гэртээ аваачиж хийхээр болоод байгаа.

- Үйл ажиллагааны тэмдэглэл хөтлөх арга

Энэ бүлгийн үйл ажиллагааны тэмдэглэл нарийн цэгцтэй хийгдсэн байна. Гэхдээ өөр бусад хүн үзээд шууд ойлгоход бэрхшээлтэй хэсгүүд байгаа тул үйлдвэрлэл, борлуулалт, зардлын талаар нэгдсэн нэг агуулга нэр төрлийн дагуу, нямбай хөтөлж явах шаардлагатай.

ii) Баянцагаан ахлагчтай бүлэг

(Анх боловсруулсан төлөвлөгөө ба үйл ажиллагааны биелэлтийн харьцаа)

Баянцагаан ахлагчтай бүлгийн үйл ажиллагааны бодит байдал ба анх боловсруулсан төлөвлөгөөг 4.6.46- 4.6.47 дугаар хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 4.6.46. Үйл ажиллагааны биелэлт ба төлөвлөлт

Бүтээгдэхүүний нэр	Үйлдвэрлэсэн тоо			Борлогдсон тоо	Борлуулалтын орлого(төг)		
	Биелэлт	Төлөвлөгөө	Төлөвлөгөөтэй харьцуулахад (%)		Борлуулалтын орлого(төг)	Төлөвлөгөө	Төлөвлөгөөтэй харьцуулахад (%)
Хүүхдийн эсгий гутал	44	132	(33.1)	17	37286	462000	(8.1)
Даллагын уут	27	144	(18.5)	3	14571	288000	(5.1)
Олбог	0	24	(0.0)	0	0	120000	(0.0)
Ноосон оймс	20	96	(20.5)	13	18686	144000	(13.0)
Шаахай	64	108	(59.5)	23	97714	540000	(18.1)
Бэлэг дурсгал	54	156	(34.6)	1	1714	312000	(0.5)
Малгай	0	24		0	0	48000	
Улавч	177	0		62	33900	0	
Ширмэл ширдэг	12	0		3	8143	0	
Аяганы суурь	11	0		0	0	0	
Цүнх	24	0		4	0	0	
Ноосон бээлий	2	0		0	0	0	
Ханын зураг	27	0		23	96171	0	
Дүн	460	684	(78.5)	149	308186	1914000	(16.1)

*2005 оны 8 сар хүртэлх тоо баримтыг ашиглан тооцоолов.

Жилд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний тоо 460 ш байгаа нь анх төлөвлөсний 80% орчим юм. Гэхдээ борлуулалт төлөвлөснөөс үлэмж доогуур төлөвлөгөөний дөнгөж 16%-д хүрснээс хэтэрсэнгүй.

Зардлын хувьд харьцангуй гайгүй, борлуулалт төлөвлөсний 16%-тай байхад зардал түүнээс нэг их илүүгүй, 21%-тай явж байна.

Орлого зарлагын тэнцлийн хувьд 2004 оны үнэлгээний үед бага боловч ашигтай гарч байсан бол энэ удаад алдагдалтай

гарч байна. Мөн энэ бүлгийн хувьд зарагдаагүй барааны үлдэгдэл их байгаа.

Хүснэгт 4.6.47.

Орлого зарлагын тэнцэл (жилээр)

(төг)	
Орлого	308,186
Зарлага	338,640
Ашиг	-30,454

* 2005 оны 8 сар хүртэлх тоо баримтыг ашиглан тооцов.

Зарим бэлэг дурсгалын зүйлээс бусад бүтээгдэхүүн хүйтний улиралд борлогддог нь үүний шалтгаан болж байна.

(Төлөвлөгөө биелэгдэхгүйд хүргэсэн хүчин зүйл ба залруулах арга зам)

▪ **Үйлдвэрлэл**

Сэмлэгч машины гинж тасарсан гэдэг шалтгаанаар ашиглахгүй байна. Гэхдээ үүнтэй адилхан машин ашигладаг Эрдэнэ сумын бүлгийн ахлагч Энхтуяа уг машинаа арчлан бүрэн ашиглаж байна. Иймд Баянцагаан ахлагчтай бүлгийнхэнд энэ тухай танилцуулж, сэмлэх машинаа түргэн хугацаанд засч, ажилдаа ашиглахыг даалгалаа.

▪ **Борлуулалт ба түүнээс олох орлого**

Борлуулалт муутай байгаа бүтээгдэхүүний хувьд борлогдохгүй байгаа шалтгаанд нь дүн шинжилгээ хийх, байдлыг өөрчлөхөд бэрхшээлтэй байгаа бол борлуулалт сайтай бүтээгдэхүүнээ дагнаж хийх зэрэг арга хэмжээ авууштай байна. Одоо мөрдөгдөж байгаа үнийн хувьд арай үнэтэйдсэн байдал зарим бараан дээр ажиглагдсан тул тэдгээр барааны хувьд тохирсон үнээр зарж борлуулах нь зүйтэй талаар зааварчилга өглөө.

▪ **Зардал**

Зардлын хувьд ерөнхийдөө зохистой түвшинд явж байна. Гэхдээ бүлгийн ахлагч Баянцагаан одоогоор цалингүй ажиллаж байгаа ба жижиг үйлдвэрээ өөрийн байшингийн нэг хэсгийг ашиглан ажиллуулж байгаа юм. Үүнээс гадна бүлгийн зардал бага байхад нөлөөлж буй бас нэг томоохон хүчин зүйл нь цалинг хийсэн бүтээгдэхүүний тоо ба ажлын нэгж үнэд тохируулан дор дор нь олгодог явдал юм.

Нөгөө талаас нь авч үзвэл түүхий эдийн зардлыг борлуулалтын орлоготой харьцуулахад ялимгүй их байна. Шалтгаан нь борлуулаагүй үлдэгдэл их байгаа, Улаанбаатараас өндөр үнэтэй ноос худалдан авдаг зэрэгтэй холбоотой.

(Өмнөх үнэлгээний үед тулгарч байсан асуудлууд ба авсан арга хэмжээ)

Өмнөх үнэлгээний үед тулгарч байсан асуудлууд ба тэдгээртэй холбоотой арга хэмжээний талаар доор өгүүлбэ.

▪ **Үйлдвэрлэлийг эрчимжүүлэх**

Өмнөх үнэлгээний үед гишүүд дөнгөж солигдсон байсан тул шинэ гишүүдэд ажлын арга барилыг тасралтгүй зааж сурган, түргэн хугацаанд чадварыг нь

Хүснэгт 4.6.48. Борлуулалтын цэг тус бүр дээрх үзүүлэлт (2005 оны 8 сар хүртэл)

		(төг, %)
Улаанбаатар	78500	(25.4)
Сумын төв	135200	(43.8)
Шанд Плаза зочид буудал	62950	(20.4)
Бусад	32200	(10.4)
Дүн	308850	(100.0)

дээшлүүлэх шаардлагатай гэсэн зааварчилга өгөгдсөн байна. Энэ удаагийн үнэлгээний үед дахин шинээр гишүүн нэмэгдээгүй байлаа. Гишүүдийн тогтворжилт ерөнхийдөө сайн, нийт гишүүдийн хувьд ч гэсэн ажлын арга чадвар дээшилж байна.

- Зах зээлээ өргөтгөх

Ноднин жилийн үнэлгээний үед 4 газарт борлуулалт хийж байсан бол энэ жилийн хувьд сумын төвийг оролцуулан нийт 5 газарт бүтээгдэхүүнээ борлуулж байна. Хэдий тийм ч борлуулалтын орлого олигтой нэмэгдээгүй байна. Хойшид ч зах зээлээ өргөтгөх шаардлагатай байна.

- Итгэмжлэн борлуулагчид буй бүтээгдэхүүний нөөцийг шалгах болон мэдээлэл олж авах

Сайншанд дахь итгэмжлэн борлуулагчид буй бүтээгдэхүүний нөөцийг 1-2 сард ганцхан удаа шалгадаг байна. Сайншандад амьдрах болсон 1 гишүүн ба Улаанбаатарт бүтээгдэхүүнээ борлуулдаг музейд ажилладаг бүлгийн ахлагчийн эгчээр дамжуулан үлдэгдэл барааныхаа нөөцийг шалгуулдаг бөгөөд энэ аргаараа үргэлжлүүлэн байнга шалгаж явах шаардлагатай.

- Худалдан авагчдын эрэлт хэрэгцээг мэдэх

Худалдан авагчдын эрэлт хэрэгцээг судалж мэдэх тухайд дараах арга хэмжээнүүд шаардлагатай байна. Үүнд: 1) худалдан авагчдын давхаргыг судлах, 2) бүтээгдэхүүний чанар, дизайны талаарх санал хүсэлтийг ажилдаа тусгах, 3) ямар бүтээгдэхүүн хамгийн их борлогдож байгаа, 4) борлуулалтын үнийг зөв тогтоох зэрэг болно.

- Үйл ажиллагааны тэмдэглэл хөтлөх арга

Үйл ажиллагааны болон санхүү бүртгэл хөтлөлт хангалтгүй байна. 1) бүтээгдэхүүний төрлүүд ба үйлдвэрлэлийн зардлын төрлүүдийг нэгдмэл нэг агуулга, нэр төрөлтэй болгох, 2) үйл ажиллагааны буюу санхүү бүртгэлийн тэмдэглэлээ дор дор нь бүрэн гүйцэд хөтөлж явах, 3) тэмдэглэлээ хэд хэдэн дэвтэрт бус нэг дэвтэрт нэгтгэн хөтөлж явах шаардлагатай.

iii) Мөнхчимэг ахлагчтай бүлэг

(Анхны төлөвлөгөөг бодит байдал (биелэлт)-тай харьцуулахад)

Мөнхчимэгийн бүлгийн жилийн турших үйл ажиллагааны биелэлт ба анхны төлөвлөгөөг 4.6.49-4.6.50 дугаар хүснэгтэд үзүүллээ. Энэ бүлэг нь төлөвлөсөн хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлээгүй, борлуулалт ч төлөвлөсөнд хүрээгүй байна. Гэрийн эсгийний үйлдвэрлэл төлөвлөгөөний 29%, эсгий гутал 3%-иас хэтрэхгүй байна. Борлуулалтын хувьд гэрийн эсгий 1155857 төг, эсгий гутал 20.000 төг байгаа

нь төлөвлөгөөний 28% ба 1% -тай тус тус тэнцэж байна. Одооор 19 ширхэг гэрийн эсгийг (жилээр тооцвол 16ш) зээлээр олгоод байгаагийн үнийг нэмж тооцвол жилийн борлуулалт 1.603.857төгрөг (39%) болж байна.

Хүснэгт 4.6.49 Биелэлт ба төлөвлөгөө (жилээр)

Бүтээгдэхүүний нэр	Үйлдвэрлэсэн хэмжээ			Зарсан тоо	Зээлээр	Борлуулалт		
	Бодит байдал	Төлөвлөгөө	Харицуулалт			Бодит байдал	Төлөвлөгөө	Харицуулалт
Гэрийн эсгий	52	178	(29.3)	46	16	1,155,857	4,094,000	(28.2)
Эсгий гутал	5	166	(3.0)	5	0	20,000	1,826,000	(1.1)
Нийт						1,175,857	5,920,000	(19.9)

2005 оны 8 сар хүртэлх тоо баримтыг ашиглав

Хэрэгцээ ихтэй гэрийн эсгийг голлон үйлдвэрлэсэн тул эсгий гутал ердөө 5 хосыг хийсэн байна.

(Төлөвлөгөө биелэгдэхгүйд хүргэсэн хүчин зүйл, залруулах арга зам)

- Үйлдвэрлэлийн хэмжээ

Үйлдвэрлэлийн хэмжээ бага байгаа нь дараах хэд хэдэн шалтгаантай холбоотой юм. Юуны өмнө цахилгааны талаар дурдах хэрэгтэй. Өнгөрсөн жил 7 хоногийн 7 өдөр цахилгаан өгдөг байсан ба 2005 оноос 7 хоногийн 5 өдөр болсон байна. Үүнээс шалтгаалж 2004 онд сард

Хүснэгт 4.6.50 Зардал төлөвлөлт ба бодит зардал (жилээр) (төг,%)

	Одоогын байдал	Анхны төлөвлөгөө	Бодит байдлыг төлөвлөгөөтэй харьцуулахад
Үндсэн түүхий эд	338593	529233	(64.0)
Цалин	1011429	1600000	(63.2)
Ус	13886	5000	(277.7)
Цахилгаан	39771	600000	(6.6)
Бусад зардал	43929	520568	(8.4)
Байрны зардал	0	120000	(0.0)
Засвар үйлчилгээ	9257	138900	(6.7)
Нийт	1456864	3513701	(41.5)

2005 оны 8 сар хүртэлх тоо баримтад үндэслэн тооцоолов

хамгийн ихдээ 16ш гэрийн эсгий үйлдвэрлэж байсан бол 2005 онд 11-ээс хэтрэхгүй болсон байна. Бас энэ жил гарч ирж байгаа шалтгаан биш ч самнагч болон сэмлэгч машины голд ноос орооцолдож байнга цэвэрлэх шаардлагатай болдгоос өдрийн цахилгаантай 3 цагт тоног төхөөрөмжөө үр бүтээлтэй ашиглаж чаддаггүй байна.

Цахилгааны хязгаарлалтаас гадна 1) ноос цуглуулах унаагүй тул ноос нийлүүлэх ажлыг малчдад даалгасан, 2) бүлгийн гишүүд бүгд үндсэн ажилтайгаас төслийн ажилд давхар ажиллах байдлаар оролцдог, 3) эвдрэл гэмтлийг түргэн хугацаанд засаж чаддаггүйгээс сул зогсох өдөр байдаг зэргийг дурдаж болох юм.

Гэхдээ 1)-р шалтгааны хувьд нийлүүлэгч, хэрэглэгч аль аль нь малчид учраас тэд өөрсдөө ноосоо авчирч өгсөн зөвхөн боловсруулалтын үнийг авч гэрийн

эсгий хийж өгөх аргыг хэрэглэж байна. Одоогоор энэ аргаар захиалга авч эсгий үйлдвэрлэх нь их болоод байна.

- **Зардал**

Түүхий эд худалдан авах үнэ ба цалин их байгаа нь зардалд ихээр нөлөөлж байна. 2004 оныг хүртэл ноос худалдан авах үнэ кг нь 150 төгрөг, үнэ өссөн үедээ 200 төрөг байсан. Гэвч 2005 оны байдлаар дундаж үнэ 300 төгрөг болсон байна. Ноос худалдан авах үнэ өссөн нь уг түүхий эдийн нийлүүлэгчид болох малчдын хувьд таатай үзэгдэл байж болох боловч ноос боловсруулах энэхүү төслийн үйл ажиллагаанд сөрөг хүчин зүйл болох юм.

Цалингийн тухайд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд тулгуурлан гаргаж ирсэн хэмжээ хэдий ч одоогийн байдлаар тогтмол цалин олгож явах нь бүлгийн үйл ажиллагааг эрхлэн явуулахад хүндрэл учруулах тул гишүүдтэй ярицан тохиролцож, цалинг хийснээр олгодог болох шаардлагатай. Дашрамд дурдахад бүлгийн ахлагч цалингүй ажиллаж байна.

- **Борлуулалтын орлого ба ашиг**

Одоогийн үнээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ үлдэгдэлгүй борлуулж чаддаг нь энэ бүлгийн давуу тал юм. Иймд борлуулах үнэ тогтмол байхад борлуулалтын орлого ба ашиг нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ болон зардлаас хамаардаг.

Одоогоор гэрийн эсгийний үнэ 1ширхэг нь 28000 төгрөг байна. Энэ үнээр борлуулахад Хөвсгөл сум болон зэргэлдээ сумууд төдийгүй Замын-Үүдээс ирж худалдан авдаг. Үнийн тухайд үндсэн түүхий эд болох ноосны үнэ өсөж байгаагаас дахин өөрчлөх боломжтой.

(Өмнөх үнэлгээний үеэр тулгамдаж байсан асуудалтай холбогдуулан авсан арга хэмжээ)

Өмнөх үнэлгээний үеэр тулгарч байсан асуудлууд ба тэдгээр асуудал тус бүрээр авсан арга хэмжээг дурдвал :

- **Үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх**

Өнгөрсөн хугацаанд хуримтлагдсан туршлага багагүй байгаа бөгөөд цаашид үйлдвэрлэлийн бүтээмжээ дээшлүүлэх шаардлагатай байна. Иймд энэ бүлэг цаашид сард 13 эсгий үйлдвэрлэж ажиллахаар шийдсэн болно.

- **Хөдөлмөрийн хөлсний өөрчлөлт**

Хөдөлмөрийн хөлсийг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээнээс хамааран олгох хэлбэрээр өөрчилнө.

Санхүүгийн мэдлэг боловсролоо дээшлүүлэх тухайд, сум хөгжүүлэх санд төлөх буцаан төлөлтийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулахын тулд 2005 оны орлого, зарлагын тооцоо болон дараа жилээс мөрдөх үйл ажиллагааны төлөвлөгөөг бүлгийнхэн өөрсдөө боловсруулсан. Бүлгийн ахлагч хэрэгтэй тоо баримтыг сайн мэдэж байгаа бөгөөд цаашид ч үйл ажиллагааны тэмдэглэлийг үнэн зөв хөтөлж явах хэрэгтэй.

- Зах зээлээ өргөжүүлэх болон эсгий гутал үйлдвэрлэх тухайд

Зах зээлээ өргөжүүлэх болон эсгий гутал үйлдвэрлэх гэхээсээ юун түрүүн хангалттай хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байх хэрэгтэй бөгөөд амьдрал дээр хэрэгцээ их байдаг гэрийн эсгий хийхэд анхаарлаа төвлөрүүлж ажиллах нь чухал байгаа.

- iv) Сум хөгжлийн санд төлөх буцаан төлөлтийн төлөвлөгөөнд оруулсан өөрчлөлт

(Энхтуяа ахлагчтай бүлэг)

Сургалтын (workshop) явцад бүлгийн гишүүд өөрсдөө гаргасан хөрөнгө оруулалтын буцаан төлөлтийн төлөвлөгөөг 4.6.51 дүгээр хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4.6.51 Буцаан төлөлтийн төлөвлөгөөний өөрчлөлт (Энхтуяагийн бүлэг)

Зардал	(Төг)		Орлого	(Төг)	
	1 жилд			1 жилд	
	Анхны хуваарь	Өөрчлөлт		Анхны хуваарь	Өөрчлөлт
Материал	264,600	192,000	Хүүхдийн гутал		200,000 (100)
Цалин	1,890,000	787,000	Тохом		240,000 (40)
Ус	1,213	10,000	Бүс		105,000 (30)
Цахилгаан	39,900	56,000	Хантайз	364,000 (56)	210,000 (30)
Бусад зардал	100,000	50,000	Тапчик (том хүн)	840,000 (105)	450,000 (100)
Байрны хөлс	240,000	200,000	Тапчик (хүүхэд)		250,000 (100)
Засварын зардал	22,340	25,000	Бэлэг дурсгал	262,500 (105)	100,000 (50)
Түлш	47,000	100,000	Улавч (эсгий)		250,000 (50)
Сум хөгжлийн санд буцаан төлөх	358,400	309,300	Улавч (нэхмэл)	1,050,000 (105)	
Нийт	2,963,453	1,729,300	Малгай	630,000 (105)	
			Нийт	3,146,500 (476)	1,805,000 (500)

Тайлбар : 1) Орлогын хаалт доторх тоо нь үйлдвэрлэлийн төлөвлөгөө юм
2) Хуулийн этгээдийн татвар (10%)ыг ашигт оруулан тооцов.

Ашиг (Төг)	
1 жилд	
Анхны хуваарь	Өөрчлөлт
183,047	75,700

Дээрхийг харгалзан хөрөнгө оруулалтын буцаан төлөлтийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж буйн гол агуулга нь дараах зүйлд оршиж байна. Үүнд:

- Хонины ноосон утсаар бүтээгдэхүүн хийж байснаасаа түр татгалзан, эсгий бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд голлон анхаарах.
- Ирэх жилээс эхлэн үйл ажиллагаагаа жигдрэх хүртэл эсгий бүтээгдэхүүн голлон үйлдвэрлэж явах юм.

- Өнгөрсөн хугацаанд илүү эрэлт хэрэгцээтэй байсан 8 төрлийн бүтээгдэхүүнийг голлон хийнэ. Ингэснээр ур чадвар сайжирч, үйлдвэрлэлийн бүтээмж дээшлэх бололцоотой юм.
- Цалинг хийснээр олгох журам нь бүлгийн гишүүдийн ажилд хандах хандлагатай ихээхэн холбоотой тул өөрчлөхгүй байх нь зүйтэй гэж үзлээ.
- Бүлгийн гишүүд цөөн байгаа нь ашиг, орлогыг бууруулах гол хүчин зүйл тул ойрын хугацаанд шинэ гишүүдтэй болох нь чухал юм.
- Дээрх заавруудыг өгсний үндсэн дээр буцаан төлөх мөнгөний хэмжээнд орох өөрчлөлтийг тооцоолон гаргав. Энэ бүлэг сумын ЗДТГ-ын мэдлийн байрыг түрээсээр ашигладаг бөгөөд байрны засварт 500,000 төгрөг зарцуулсан байна. Сумын ЗДТГ байрны түрээсийн өртгийг төлөхийг шаардаж байгаа. Сумын ЗДТГ-ын зүгээс энэ бүлгийн үйл ажиллагааг өндөр үнэлж, бололцооны хирээр дэмжиж туслах үүднээс ажлын байрны засварт зориулсан 500000 төгрөгийг Сум хөгжлийн "Улаан Уул" санд буцаан төлөхөөс чөлөөлөхөөр боллоо.
- Ингээд байрны засварт зориулсан зардлыг хөрөнгө оруулалтын буцаан төлөлтийн нийт дүнгээс хасаж, 1,387,200 төгрөгийг 2005 онд 150,000төг, үлдсэн 4 жилд жил бүр 309,300 төгрөгөөр хуваан төлж барагдуулахаар боллоо (4.6.50 дугаар хүснэгт).

Хүснэгт 4.6.52
Жил бүр буцаан төлөх
мөнгөний хэмжээ

	(Тг)
Эхний жил	150,000
2дахьжил	309,300
3дахь жил	309,300
4дэх жил	309,300
5дахь жил	309,300
Нийт	1,387,200

(Баянцагаан ахлагчтай бүлэг)

Бүлгийн гишүүд Сургалт(workshop)-ын явцад өөрсдөө өөрчлөн засварласан хөрөнгө оруулалтын буцаан төлөлтийн төлөвлөгөөг хүснэгт 4.6.53-т харуулав. Буцаан төлөлтийн төлөвлөгөөнд оруулж буй өөрчлөлтийн үндэслэл нь доор дурьдсан 5 зүйлд оршино.

Хүснэгт 4.6.53 Буцаан төлөлтийн хуваарийн өөрчлөлт (Баянцагааны бүлэг)

Зардал	1 жилд (төг)		Орлого	1 жилд (төг)	
	Анхны хуваарь	Өөрчлөлт		Анхны төлөвлөлт	Өөрчлөлт
Материал	223,560	52,000	Бэлаг дурсгал	312,000 (156)	300,000 (60)
Цалин	1,200,000	558,450	Оймс	144,000 (96)	
Ус	962	12,000	Даллагын уут	288,000 (144)	140,000 (140)
Цахилгаан	68,400	34,800	Улавч		360,000 (30)
Бусад зардал	122,000	100,400	Ширдэг		250,000 (50)
Засвар	11,790	20,000	Табчик	540,000 (108)	180,000 (30)
Буцаан төлөх	188,000	94,320	Оролт		
Нийт	1,814,712	871,970	Хүүдийн гутал	462,000 (132)	
			Олбог	120,000 (24)	
			Малгай	48,000 (24)	
Ашиг	1 жилд (төг)				
	Анхны хуваарь	Өөрчлөлт	Нийт	1,914,000 (684)	1,230,000 (310)
	99,288	358,030			

2) Хуулийн этгээдийн татвар (10%-ийг ашигт оруулан тооцов

Тайлбар: 1) Орлогын хаалтан доторх тоо нь үйлдвэрлэлийн хэмжээ

- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тухайд борлуулалтын байдлаас дүгнэлт хийж, борлуулалт сайтай бүтээгдэхүүнээ дагнан хийх.
- Улаанбаатараас өндөр үнэтэй, сайн чанарын ноос худалдан авдаг нь ашиггүй ажиллах хүчин зүйлийн нэг болж байна. Сумын худалдан авагчид ноосны чанарыг нэг их голдоггүй тул Улаанбаатараас авсан өндөр үнэтэй ноосыг аль болох бага хэрэглэх хэрэгтэй.
- Цалин хөлсний хувьд нэгж бүтээгдэхүүний тоо ба төрөл тус бүрээр олгодгийг өөрчлөхгүй байх.
- Бусад зардлаа эргэн харж, багасгах.
- Дээрх заавруудыг өгсний үндсэн дээр Сум хөгжлийн санд буцаан төлөх хугацаа 5 жил байсыг 10 жил болгон сунгаж, 1 жилд төлөх зардлын хэмжээг 188,640 төгрөгөөс 94,320 төгрөг болгон бууруулахаар болов. Буцаан төлөх зардлын нийт дүнд өөрчлөлт орохгүй.

Энэ бүлэгт нийлүүлсэн тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа 5-7 жил бөгөөд 10 жил болгож сунгасан нь уг хугацаанаас арай урт байгаа юм. Гэвч энэ бүлгийн гишүүд бүгд үндсэн ажлынхаа хажуугаар өдөрт хэдхэн цаг үйлдвэрлэл явуулдгийг харгалзан үзвэл 10 жил гэдэг нь тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаанаас авч үзэхэд боломжийн хугацаа гэж үзэж байна.

(Мөнхчимэгийн бүлэг)

2005 оны 9 сард явуулсан сургалтын (workshop) үеэр бүлгийн санхүүгийн байдлыг сайтар судлан үзсэний үндсэн дээр хөрөнгө оруулалтын буцаан төлөлтийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулав (4.6.54 дугаар хүснэгтийг үзнэ үү).

Хүснэгт 4.6.54 Буцаан төлөлтийн төлөвлөгөөний өөрчлөлт (Мөнхчимэгийн бүлэг)

Зардал	1 жилд (төг)		Орлого	1 жилд (төг)	
	Анхны төлөвлөгөө	Өөрчлөлт		Анхны төлөвлөгөө	Өөрчлөлт
Материал	529,233	585,000	Гэрийн эсгий	4,094,000 (178)	1,852,500 (65)
Цалин	1,600,000	650,000	Эсгий гутал	1,826,000 (66)	
Ус	5,000	48,750	Нийт	5,920,000 (244)	1,852,500 (65)
Цахилгаан	600,000	90,000	Ашиг	1 жилд (төг)	
Бусад зардал	520,568	20,000		Анхны төлөвлөгөө	Өөрчлөлт
Байрны түрээс	120,000	0		1,414,156	53,750
Бусад зардал	138,900	55,000	Тайлбар: 1) Орлогын хаалтан доторх тоо нь үйлдвэрлэлийн хэмжээ		
Буцаан төлөх	992,143	350,000	2) Хуулийн эпээдийн татвар (10%)-ийг ашигт оруулан тооцов.		
Нийт	4,505,844	1,798,750			

Буцаан төлөлтийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж буй хүчин зүйлүүдийг доор дурдъя.

- Сард үйлдвэрлэх гэрийн эсгийний тоог 10-аас 13 болгож өсгөх.
- Эсгийний үнийг 28,000 төгрөгөөс 28,500 төгрөг болгож бага зэрэг өсгөх.
- Цалин хөлсийг үйлдвэрлэлийн хэмжээтэй уялдуулан тогтооно.
- Үйл ажиллагааны өнөөгийн байдлыг харгалзан үзэж сумын ЗДТГ-аас цахилгааны төлбөрийг сард 18,000 төгрөг байхаар бууруулан тогтоолгож авах.
- Эсгий гутлын үйлдвэрлэлийг түр зогсоож, эрэлт хэрэгцээ ихтэй гэрийн эсгийг голлон үйлдвэрлэх.
- Дээрхи 5 зүйлийг хэрэгжүүлбэл сар бүр сумын хөгжлийн санд 70,000 төгрөг буцаан төлөх боломжтой болно. Үйлдвэр нь 5 сараас 9 сар хүртэл ажиллана гэж үзвэл жил бүр Сум хөгжлийн санд 350,000 төгрөг буцаан төлнө гэсэн үг юм.
- Цахилгааны хангалт зэрэг гадаад хүчин зүйлийн нөлөө арилсан тохиолдолд сумын ЗДТГ-тай ярилцан хөрөнгө оруулалтын буцаан төлөх хугацааг богиносгоно.

Буцаан төлөлтийн төлөвлөгөөг ийнхүү өөрчилснөөр буцаан төлөх хугацаа 20 жил болно. Энэ бүлэгт нийлүүлсэн тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа нь үйлдвэрлэгчийн баталж буйгаар бол 10-15 жил болно. Гэвч сумын төвийн цахилгаан хамгамжийн нөхцөл байдлаас хамааран өдөрт 3 цаг ажилладаг, хүйтний улиралд 10 сараас 3 сар хүртэл зогсдог болон тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа урт зэрэг талуудыг нь аваад үзвэл хөрөнгө оруулалтын буцаан төлөх хугацаа 20 жил байхад боломжийн гэж үзэж байна.

4.6.6 “Гар худгийн кампанит ажил” төсөл

(1) Зорилго ба үндсэн чиглэл

Өнөөгийн байдлаар, засвар арчлалтад нь гарах зардал харьцангуй хямд бөгөөд малчдын малаа услах чухал уст цэгийн нэг болох гар худаг байгуулалтын ажил урагштай бус байгаа нь одоогийн МАА-н тогтолцоог авч явах тал дээр шийдвэрлүүштэй асуудлын нэг болоод байна. Гар худаг гаргах ажил идэвхтэй өрнөхгүй байгаа нь дараах шалтгаантай холбоотой гэж үзэж байна. Үүнд:

- Малчдад өөрсдөө гар худаг гаргаж, ашиглах идэвхи санаачлага дутагдаж байна.
- Гар худгийг малчид өөрсдийн хүчээр гаргаж чаддаггүй.
- Малчид гар худаг гаргах технологи мэдэхгүй.
- Гар худаг гаргах ажил эрсдэл ихтэй.
- Хөдөө орон нутагт материал худалдан авахад хүндрэлтэй байдаг.
- Хөдөө орон нутагт материалын олдоц муу
- Ажиллах хүч дутагдалтай.
- Малчдаас бусад байгууллага, хүмүүс гар худаг гаргах ажлыг сонирхдоггүй.

Гар худаг гаргах ажил хангалттай хэмжээнд явагдахгүй байгаа нөхцөл байдлыг засаж сайжруулан, сумын зүгээс гар худаг гаргах ажлыг зохион байгуулж, өрнүүлэх чадварыг бий болгох зорилгоор энэ төслийг хэрэгжсэн болно. Энэхүү зорилгыг биелүүлэхийн тулд дор дурьдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай болно. Үүнд:


- Гар худгийн кампанит ажлын явцад гар худаг гаргах талаар сургалт явуулах (сум бүрт 2 худаг дээр зохион байгуулсан)
- Сумдад шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж олгох (4.6.55-д өгөгдсөн бүснэгт)
- Сумын захиргаа багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хадгалалт хамгаалалтыг хариуцах чадварыг эзэмших (худаг гаргахад зааварчилгаа өгөх, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хяналт, тэдгээрийг зээлээр өгөх үеийн хяналт).
- Малчид өөрсдийн хүч хөрөнгөөр гар худаг гаргадаг болох

(2) Төслийн бүтэц, зохион байгуулалт

Төслийг гардан хэрэгжүүлэгч нь сумын ЗДТГ боловч судалгааны багийн зүгээс төслийг эхлүүлэх бэлтгэл болгон гар худаг гаргах ажлын мэргэжилтэн урьж ажиллуулан, худаг гаргахад шаардлагатай тоног төхөөрөмжийг бэлдсэн ба мөн гар худаг гаргах ажлын зааварчилгаа гаргаж (хавсралт L-ийг үзнэ үү), сумын ЗДТГ-т тусламж үзүүлсэн.

Сумын захиргаа нь кампанит ажил эхлэх үеэр явагдах гар худгийн сургалтад оролцох малчдаа зохион байгуулж оролцуулахын хамт өөрсдөө мөн адил хамрагдан гар худаг гаргах арга барил, технологийг сурч, цаашдаа сумын хэмжээнд өргөжүүлэн дэлгэрүүлэхэд анхаарал тавина.

Тэрчлэн гар худгийн ажилд хэрэглэгддэг багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хадгалалт хамгаалалтыг хариуцаж, түрээсээр ашиглуулах, ашиглалтын төлбөрийг хураан авах зэрэг ажлыг зохион байгуулахаас гадна тэдгээрийг ашиглахын ач холбогдлыг малчдад сурталчлан таниулж, өргөн хүрээ хамарсан үйл ажиллагаа явуулахыг зорино. Сум бүрт 2 худаг гаргахад ашиглахаар тооцож нийлүүлсэн материал нь кампанит ажил эхлэх үеэр ашиглагдаж дуусна. Иймд сумын захиргаа малчдад зарсан материалын үнээр кампанит ажлыг цаашид үргэлжлүүлэхэд шаардагдах материал худалдан авч нөөцлөх зэргээр гар худаг гаргах сонирхолтой малчдыг дэмжих үйл ажиллагааг тасралтгүй явуулах шаардлагатай юм. Аймгийн удирдлага судалгааны багтай хамтран дээр дурьдсан үйл ажиллагаанд мониторинг хийнэ.



(3) Төслийн төлөвлөлтийн агуулга

1) Гар худаг байгуулалтын өнөөгийн байдал

Төсөл эхлэхээс өмнөх үеийн 3 сумдад гар худаг ашиглалтын байдал доорх хүснэгтэд харуулсанчлан харилцан адилгүй байна. Сумын захиргаанд гар худаг гаргах ажлыг дэмжих хэмжээний хөрөнгө мөнгө байхгүйгээс ихэвчлэн малчид өөрсдийн санаачлага, хүч хөрөнгөөр гарган ашиглаж буй байдалтай байна.

Хүснэгт 4.6.55 Туршилтын төсөлд хамрагдаж байгаа 3 сумд дахь гар худгийн ашиглалттай холбоотой мэдээлэл

		Эрдэнэ сум	Улаанбадрах сум	Хөвсгөл сум
Гар худгийн ашиглалтын өнөөгийн байдлын талаарх сумын удирдлагын ойлголт, байр суурь		Худгийн тоо хангалтгүй. Хуучин худгийг сэргээн засварлаж ашиглалтын байдлыг сайжруулах шаардлагатай. Шаардлагатай газарт шинээр гаргах хэрэгтэй байна.	Сумын хэмжээнд гар худаг хангалттай гэж үзэж байна. Гэвч сүүлийн жилүүдэд усны түвшин доошилж байгаад санаа зовж байна.	Сумын гар худгуудын ундарга хангалтгүй, малчдын хэрэгцээг хангаж чадахгүй байна. Гэвч зудаар мал хорогдож, малын тоо цөөрсөн байгаа тул одоогийн байдлаар аргалж болно гэж малчид үзэж байна.
ХХААЯамаас явуулсан геофизикийн хайгуул, судалгааны дүн		2002 онд 50 цэгт хайгуул хийж 16-д нь ус илэрсэн. Үүнээс 10 нь бага гүнтэй, гар худаг гаргаж ашиглаж болохоор байна.	60 цэгт хайгуул хийж, 16-д нь ус илэрсэн. Гэвч бүх цэг нь 5 метрээс доош гүнтэй байна.	2001 онд 58 цэгт хайгуул хийж 18-д нь ус илэрсэн. Харин бүх ус нь 5 метрээс доош гүнтэй байх ба 10 метрээс доош гүнтэй 13 цэг байна.
Гаргасан худгийн тоо	2000 он	Малчид 3 худгийг, сумын санхүүжилтээр 1 худгийг сэргээн засварласан.	Байхгүй.	Малчид 2 худаг гаргасан.
	2001 он	Малчид 1 худаг шинээр гаргасан.	Малчид 8 худаг шинээр гаргасан (Улсын гар худгийн тэмцээнд 3-р байранд орсон. Сангийн далай багт)	Малчид 2 худаг шинээр гаргасан.
	2002 он	Малчид 1 худаг шинээр гаргасан.	2 худаг	Малчид 3 худаг шинээр гаргасан.
	2003 он	Малчид 4 худаг шинээр гаргасан. Үүнээс 2 –ыг нь геофизикийн хайгуулаар ус илэрсэн газарт, 1-ийг нь ашиглаж буй худгийн хажууд гаргасан байна.	Байхгүй.	Малчид 4 худаг шинээр гаргасан.
Ажиллах хүчний дэмжлэг	Малчдын бүлэг	Малчдын бүлэг	Худгийг ашиглах бүлгийн гишүүдээс гадна ажиллах хүчний дэмжлэг хэрэгтэй	
Гар худгийн тоог нэмэгдүүлэх зорилгоор сумын захиргаанаас авсан арга хэмжээ	Суманд гар худаг гаргах ажлыг санхүүжүүлэх хөрөнгө байхгүй.	Ажиллах хүчний дутагдлыг нөхөх, ажилгүйдлийн эсрэг арга хэмжээ авах үүднээс ажилгүй хүмүүсийг гар худгийн барилгын ажилд оролцуулж, цалинжуулах. Цэргийн дүйцүүлэх албаны залуучуудыг худгийн ажилд оролцуулах.	Ажиллах хүчний дутагдлыг нөхөх зорилгоор дүйцүүлэх албаны залуучуудыг гар худгийн ажилд оролцуулах. Сумын зүгээс санхүүжилт хийгдэхгүй байгаа.	
Гар худаг гаргахад тулгарч байгаа хамгийн бэрхшээлтэй асуудал	Ажиллах хүч хангалтгүй, хөрөнгө мөнгө хүрэлцээгүй, малчдын бие даасан санаачлагатай үйл ажиллагаа дутагдаж байна, шавхах насос зэрэг тоног төхөөрөмж хүрэлцээгүй.	Хэдэн метрийн гүнд хэр ундаргатай уст цэг байгааг урьдчлан мэдэх аргагүй.	Малчид өөрсдөө ус байх эсэхийг магадлах боломжгүй. Малчид гар худаг гаргах сонирхолтой байгаа ч хөрөнгө мөнгө, ажиллах хүч хангалтгүй.	

2) Гар худаг гаргах ажлыг дэмжих тогтолцоог бий болгоход тулгарч буй асуудлууд ба тэдгээрийг шийдвэрлэх арга

i) Малчид гар худаг гаргахад учирдаг бэрхшээл

Гар худаг гаргах ажил идэвхтэй өрнөхгүй байгаа нь дараах 3 зүйлээс голлон шалтгаалж байна. Үүнд:

- Гар худаг гаргах газар, ухах гүнийг урьдчилан тодорхойлох боломжгүй
- Ажиллах хүч хангалтгүй
- Материал тоног төхөөрөмж худалдан авахад бэрхшээлтэй

ХХААЯ гар худаг гаргах ажлыг дэмждэг боловч олон түмэн гар худаг зэргийг малчид өөрсдөө гаргаж л байдаг гэж бодож явдаг. Малчид ч шаардлага гарвал худаг гаргаад ашиглана гэсэн бодолтой явдаг боловч янз бүрийн хүндрэл, бэрхшээлийн улмаас шаардлага хангасан худаг гаргаж чаддаггүй байна.

ii) Шийдвэрлэх арга зам

Цаашид гар худаг гаргах ажлыг өрнүүлэхийн тулд дээр дурьдсан асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай юм. Гэвч сумын төсөвт гар худгийн ажилд зориулах хөрөнгө, мөнгө тусгагддаггүй тул малчид өөрсдийн хүч хөрөнгөөр гаргахаас өөр арга зам байхгүй байна. Харин сумдад гар худаг гаргаж ашиглая гэсэн малчдад дэмжлэг үзүүлэх зохион байгуулалт, тогтолцоог бий болгох шаардлагатай юм

(Гар худаг гаргах газар, гүнийг тогтоох)

ХХААЯамнаас явуулсан геофизикийн хайгуул судалгаагаар сумдад гар худаг гаргахад тохиромжтой бага гүний уст цэг цөөн байгаа нь тогтоогдсон. Уламжлалт аргаар малчдын туршлага, ажиглалт дээр үндэслэн ус гарч болзошгүй газрыг сонгодог ч энэ нь хөрөнгө, хүч зарцуулан ажил эхлэхэд хангалттай үндэслэл болж чаддаггүй байна. Энэ мэтчилэн уст цэгийг тогтооход учирч буй хүндрэл нь гар худаг байгуулах ажил өрнөхгүй байгаагийн нэг гол шалтгаан болж байгаа юм. Иймд юуны өмнө урьд нь ашиглаж байсан худгийн ойролцоо ус гарах магадлал өндөр байдгийг харгалзан үзэж, гар худгийг сэргээн засварлах ажлыг эхний ээлжинд өрнүүлэх шаардлагатай байна. Судалгааны үеэр сургалтаар худаг гаргахдаа 2 газарт усны хайгуул хийсэн. Түүнээс хойш хуучин худгуудыг эхний ээлжинд сэргээн засварлах ажлыг санал болгож ирсэн болно.

(Ажиллах хүчний асуудал)

Суманд гар худаг гаргах ажил идэвхтэй өрнөвөл малчид худаг гаргахдаа бие биендээ харилцан тусалдаг зохион байгуулалтад орж болох юм. Эрдэнэ суманд баг хоорондын хамтарсан үйл ажиллагаа идэвхтэй явагдаж, малчид хамтран ажиллаж, харилцан тусалцах явдал хэвшмэл байдгаас гар худаг гаргахад ажиллах хүч

дутагдах асуудал гарахгүй байна. Сумдын ЗДТГ-аас идэвхийлэн малчдыг уриалан зохион байгуулж, тэдний ухамсарт өөрчлөлт гаргаж явах шаардлагатай.

Ажиллах хүчийг бүрдүүлэхийн хувьд хөдөлмөрийн хөлс олгох асуудлыг шийдэж чадвал сумын төвийн ажилгүйчүүдийг хөлслөн ажилуулах боломжтой юм. Гэвч хөдөлмөрийн хөлс олгож худаг гаргуулах сонирхолтой малчин байх эсэхэд асуудлын гол нь орших тул гар худаг гаргаж ашиглахын ач холбогдол, давуу талыг олон түмэнд таниулан сурталчлах үйл ажиллагааг өргөн явуулах нь чухал юм.

Судалгааны үеэр Эрдэнэ суманд орон нутгийн болон багийн даргын удирдлагаар гар худгийг хамтран засварлах ажил тодорхой хэмжээнд бие даан явагдаж чадахуйц механизм бүрдсэн. Улаанбадрах, Хөвсгөл сумдын хувьд сумын ЗДТГ-аас цэргийн дүйцүүлэх албаны залуучуудыг сум орон нутгийн хэмжээний ажилд татан оролцуулдаг механизмаа ашиглан гар худаг байгуулалтын ажлыг зохион байгуулсан. Энэ ажлын зохион байгуулалтыг цаашид улам сайжруулснаар ажиллах хүчний дутагдлыг нөхөх, залуучуудад гар худаг гаргах арга барил, технологийг өвлүүлэх зэрэг үр дүнд хүрэх юм.

(Материал, тоног төхөөрөмж нийлүүлэлт)

Малчид тус тусдаа гар худагт орох багахан хэмжээний материалыг хувиараа олж авахад тээврийн зардал өндөр болохоос гадна ихээхэн хүч, цаг зарцуулна. Иймд шаардлагатай материал багаж, хэрэгслийг сум нэгдсэн журмаар худалдан авч түүнээсээ малчдад нийлүүлж байвал малчдад учрах санхүүгийн болон цаг хугацааны хүндрэлийг хөнгөвчилж болох юм. Үүний хөрөнгийн эх үүсвэрийг "Сумын худгийн сан" –гаас гаргаж болох юм. .

Мөн гар худгийн ажилд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүд нь өдөр тутмын амьдралд тэр болгон хэрэг болдоггүйгээс шаардлагатай үед сумын хэмжээгээр хайгаад олдохгүй тохиолдол ч байдаг. Гар худаг гаргах малчид өөрсдөө эдгээр төхөөрөмжийг худалдан авах нь хүндрэлтэй байдаг тул сумын захиргаа мэдэлдээ байлгаж, ашиглахыг хүссэн хүнд түрээслүүлж байх нь илүү үр дүнтэй арга болно гэж үзэж байна.

3) Гар худгийн бүтэц ба барих арга


i) Бүтэц ба барих арга

Хөрс ба байгаль орчны нөхцлөөс хамааран гар худгийг чулуугаар хашсан, модоор хашсан гэсэн үндсэн хоёр хэлбэрт хувааж үздэг байна. Судалгаанд хамрагдаж байгаа говийн бүс нутагт хөрс нь элсэрхэг, нурамтгай, модон материалын олдоц муу байдаг зэргээс шалтгаалан ихэвчлэн чулуун хашлагат худаг байгуулдаг байна.

а) Бүтэц

Чулуугаар хашсан худгийн бүтцийг 4.6.20 дугаар зурагт үзүүлэв.

- Ус хүлээн авч нөөцлөх хэсгийг хангалттай зайтай болгохын тулд ус авах хэсэг (цээл)-ийн хашлагыг хүнхэр хийнэ.
- Ус хүлээн авах хэсгийг чулуугаар хашихдаа хашлага чулууны завсраар дэрс зэргийн ургамлаар жийрэг хийж, чулуунуудыг нурахааргүй өрнө. Энэ жийрэг нь шүүлтүүрийн үүргийг давхар гүйцэтгэнэ.
- Ус хүлээн авах хэсгийн дээд талын хашлагыг хийхдээ чулууг цементэн зуурмагаар гагнаж өрнө. (модоор хаших тохиолдолд энэ хэсгийг модоор хийнэ)
- Худагт гадаргын бохир усыг оруулахгүйн тулд амсрын доод хэсэгт худгийн хашлагын гадна талаар 1 метр хүртэл гүнд шавар манаас хийнэ.



Зураг 4.6.20 Чулуугаар хашсан худгийн бүтэц

б) Барих арга

(Байршлыг тогтоох)

Геофизикийн хайгуул судалгааны үр дүн, ашиглагдаж буй гар худаг, газрын гадаргуу ба ургамлын шинжийг харгалзан үзэж худаг гаргах газрын байршлыг тогтооно. Боломжтой бол геофизикийн хайгуул судалгаа болон өрөмдлөг хийж, ус илрэх гүнийг урьдчлан тогтоовол зохино.

(Материал, тоног төхөөрөмжийг бэлтгэх)

Худаг гаргах ажил эхлэхээс өмнө шаардлагатай материал, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг бэлтгэнэ. Мөн худаг ухах ажилчдын байрлах байр, сууцыг бэлэн болгох хэрэгтэй. Дор дурьдсан материалыг хаанаас татаж авахаа шийдсэн байх бөгөөд аль болох ойрхон газраас авахыг хичээнэ.

Хүснэгт 4.6.56 Газар дээрээс нь цуглуулах материалууд


Материалын нэр	Шаардлагатай хэмжээ
Чулуу	19м ³ (5 ачааны машин)
Хайрга	3.8м ³ (1 ачааны машин)
Дэрс	0.5 м ³ (Хагас ачааны машин)

в) Ажиллах хүчийг бэлдэх

Худаг гаргах ажилд 8 орчим ажилчид оролцоно. Энэхүү ажиллах хүчийг худаг ашиглах малчин өөрөө бэлдэх ёстой. Судалгааны явцад сургалтаар худаг гаргах үед багийн дарга ажлыг хянаж, багаасаа сайн дураар ажиллах хүмүүсийг гарган ажиллуулсан. Эрдэнэ сумын хувьд үүний дараа дараагийн худгийн хувьд малчид өөрсдөө ойр хавийнхаа малчидтай хамтран ажилласан. Аюулгүй ажиллагааг хангах үүднээс ажилчдын дотор өмнө нь гар худаг гаргаж байсан туршлагатай хүн байх нь зүйтэй.

г) Гар худгийг ухах

- Худаг ухахдаа хөрсний байдалтай уялдуулан 2.0 - 3.0 метрээс багагүй голчтойгоор алсаас шатлан ухна.
- Ус илэрсэн үеэс 1 орчим метр гүн ухаж хангалттай ундаргатай байлгана.
- Чулуу, хайрга зэрэг зөөж ирж, цэгцлэн бэлтгэнэ.
- Дэрсээр жийрэг хийж, худгийн ус хүлээн авч нөөцлөх хэсгийн ханыг тогтвор сайтай чулуугаар хашна.
- Худгийн уурхайн хэсгийн хана, хашлагын завсрыг хайргаар дүүргэнэ.
- Худгийн амсрын хэсэгт 70 см хүртэл өндөр хүзүүвч хийнэ.



Зураг 4.6.21 Гар худгийн бүтэц

ii) Шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж

(Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж)

Нэг гар худаг гаргахад шаардагдах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг 4.6.57 дугаар хүснэгтэд харуулав. Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг сум тус бүрт 3 иж бүрдлээр нийлүүлсэн. Эдгээр багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн үнэ өртөг, эдэлгээний хугацааг харгалзан түрээсийн тариф тогтоож, сумын захиргаанаас малчдад түрээсээр хэрэглүүл болсон. Туршилтын судалгааны эдгээр багаж хэрэгслийг Улаанбаатараас бөөнд нь худалдан авч, сумд руу тээвэрлэн хүргүүлсэн.

Хүснэгт 4.6.57 Шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалт

Тоног төхөөрөмжийн нэр	Тоо хэмжээ	Нэгж үнэ (Төг)	Түрээсийн төлбөр(төг)	
			1 иж бүрдэл	1 ш
Хүрз	6	3,900	1,030	180
Жоотуу	2	4,100	220	110
Алх	1	9,000	240	240
Лом	2	4,200	230	120
Рантуу	1	2,600	70	70
Тэргэнцэр (2 дугуйтай)	3	50,000	4,380	2,190
Цүүц	1	4,000	110	110
Хөрөө (том)	1	8,400	230	230
Хөрөө (жижиг)	1	6,300	170	170
Гар сүх	1	10,000	270	270
Олс	40	400	2,100	2,100
Хувин	3	2,800	1,110	370
Гадас	3	5,000	990	330
Ус шавхах насос + шланг	1	500,000	13,130	13,130
Ажлын малгай	3	3,800	500	170
Усны гутал (урт түрийтэй)	2	13,500	1,780	890
Ажлын хувцас	7	4,800	1,470	210
Ажлын бээлий	20	500	13,130	660
Хүрз, жоотууны иш	3	500	400	140
Шат, тавцангийн модон материал	5	1,500	330	70
Нийт	-	-	41,890	21,760

(Чулуу, дэрс зэрэг материалыг зөөх тээврийн хэрэгсэл)

Мод, цемент зэрэг материалыг худалдаж авах бөгөөд жийрэг хийх дэрс, хашлагын чулуу зэрэг материалыг малчид өөрсдөө ойр хавиасаа бэлтгэнэ. Гэвч эдгээр материалыг татан авахад шаардагдах ачааны машин хөлслөхөд нэмэгдэл зардал гарахаас гадна цаг хугацаанд баригдах зэрэг бэрхшээл үүсэж болзошгүй юм. Иймд төслийн хүрээнд сумын захиргаанд бага оврын трактор нийлүүлж, малчид уг тракторыг хямд төлбөр төлж түрээсээр ашиглахаар зохион байгууллаа.

Тракторын ашиглалтын төлбөрийг худалдаж авсан үнийг нь үндэслэн тогтоосон болно. Ашиглалтын төлбөр нь дараахь байдалтай байна.

- (1) Тракторын үнэ (тээврийн зардал, татварыг оролцуулсан) : 3,065,400 төгрөг
 (2) Тооцоолж буй эдэлгээний хугацаа: 10 жил
 (3) Тооцоолж буй ашиглалтын байдал : 8 удаа/жил
 (4) Засвар үйлчилгээний зардал: Зардлын 5%/жил
 (5) Нэг удаагийн ашиглалтын төлбөр=40,000 орчим төгрөг [(1)×1.05/(2))/(3)]

Туршилтын судалгаагаар нийлүүлсэн тракторыг хувь хүний эрхэлдэг дэлгүүрээр дамжуулан Хятад улсаас худалдан авсан ба уг тракторын чиргүүлийн материал нь муу бөгөөд эвдрэл гарах явдал байсан.

(Материал)

Худгийн ойр орчмоос бэлтгэх материалаас гадна дор дурьдсан материалуудыг урьдчилан худалдан авсан байх шаардлагатай

Хүснэгт 4.6.58 Худалдан авах материалууд

	Шаардлагатай хэмжээ	Тодотгол	Нэгж үнэ (Төг)	Төсөв(Төг)
Дунз	8ш	0.15 x 0.15 x 4.0	1,500	12,000
Банзан	3ш	0.05 x 0.15 x 4.0	1,333	4,000
Цемент	6 шуудай (300кг)	50кг	3,500	21,000
Хадаас	3 кг	100мм	1,000	3,000
Нийт				40,000

(Түлш шатахууны зардал)

Ус шавхах насос, трактор ашиглахад түлш шатахууны зардал гарна.

Хүснэгт 4.6.59 Түлш шатахууны зардал

	Шаардлагатай хэмжээ	Тодотгол	Нэгж үнэ (Төг)	Төсөв(Төг)
Ажлын насосны түлш	10 л	A-76	450	4,500
Тракторын түлш	150 л	Дизель түлш	535	80,250

* Трактораар 7-8 км зайтай газрууд руу явах үед зарцуулагдах түлшний хэмжээ

iii) Худгийн ажлын зардал ба малчдын хариуцах зардлын хэмжээ

Гар худаг гаргахад дор дурьдсан хэмжээний зардал гарна.

Хүснэгт 4.6.60 Худаг гаргах ажлын зардал

	Тоо хэмжээ	Үнэ(төг)
Материалын зардал	1 иж бүрдэл	40,000
Тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал	1 иж бүрдэл	41,890
Трактор түрээслэх зардал	1 ш	40,000
Түлш шатахууны зардал	1 иж бүрдэл	84,750
Нийт		217,520

Үүнээс гадна ажилчдын хөдөлмөрийн хөлс, хоол ундны зардал гарч болно.

Материал, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал болон ажилчдын хөдөлмөрийн хөлсийг худаг гаргах малчин бүрэн хариуцна. Ялангуяа ажил удаашрах тусам хөдөлмөрийн хөлс болон хоол ундны зардал улам өснө гэдгийг малчид сайтар ойлгосон байх шаардлагатай.

Дээрх зардлуудыг нэгэн зэрэг гаргах боломжгүй бол сумын худгийн сангаас дэмжлэг авч болохоос гадна материал худалдан авахад гарсан зардал болон багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалтын хөлсийг буцаан төлөх арга хэлбэрийн талаар сумын удирдлагатай зөвлөлдсөний үндсэн дээр хэсэгчлэн төлж болно.

4) Мониторинг хийхэд анхаарах зүйл

i) Гар худаг гаргах ажлын явц

(Компанит ажлын үр дүн)

Гаргасан худгийн тоо, худгийн гүн, ундарга зэрэг худгийн хүчин чадлын үзүүлэлтүүд болон худгийн ажлын технологийг магадлаж, төслийн үр дүнг судална. Мөн худгийн ажилд нийлүүлсэн материал, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж хэрхэн ашиглагдсаныг шалгаж, төслийн үр ашигтай байдлыг нягтлан судална.

(Гар худаг гаргасны үр дүн)

Гар худаг гаргаснаар мал услах хугацаа богиносгох, бэлчээрийн талхлагдал багасах зэрэг ямар нэгэн эерэг үр дүн гарсан эсэхийг магадлана.

(Гар худгийн ажилд саад болсон хүчин зүйлүүдийг тодорхойлох)

Гар худгийг гаргасан малчдын бүлгээс гадна барих гэж байгаад больсон малчдын бүлгүүдээс уг шалтгааныг нь тодруулж, цаашид төслийн агуулгад оруулах засвар, өөрчлөлтийн талаар нягтлан судална.

ii) Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалт

(Сумын захиргааны зүгээс багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хадгалалт хамгаалалтыг хариуцах чадвар)

Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хадгалалт хамгаалалтын байдал, ялангуяа энэ удаа олноор нийлүүлэгдсэн жижиг, сажиг багаж хэрэгслийн ашиглалт хамгаалалтын байдалтай танилцаж, алдагдаж үрэгдсэн зүйл байгаа эсэхийг магадлана. Тэрчлэн багаж хэрэгсэл, төхөөрөмжийг түрээсээр ашиглуулж буй байдал, ашиглалтын төлбөрийг хураан авч буй арга хэлбэртэй танилцаж, багаж хэрэгсэл, төхөөрөмжийн ашиглалт хамгаалалт, шинэчлэлтийн зүй зохистой арга зам, боломжийг нягтлан судалж үзнэ.

(Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалтын байдал)

Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг түрээсээр ашиглуулж ирсэн байдал, эвдрэл гэмтлийн байдалтай танилцаж, түрээсийн төлбөрийн хэмжээг магадлан судалж, тоног төхөөрөмжийн жагсаалтад засвар оруулна.

iii) Бэлчээрийн менежмент

(Бэлчээр ашиглалтад гарсан өөрчлөлт)

Гар худаг гаргаснаар бэлчээр ашиглалтын байдалд бий болсон өөрчлөлт, гаргасан худгийн үзүүлэх үр нөлөөг магадлан судална.

(4) "Гар худгийн кампанит ажил" төслийн биелэлт

1) Гар худаг байгуулалтын ажлын биелэлт

Энэ оны 9-р сар хүртэл хугацаанд төсөлд хамрагдсан 3 суманд шинээр гаргасан болон сэргээн засварласан гар худгийн тоо 21-д хүрсэн бөгөөд төсөл эхлэх үед сургалтаар гаргасан 6 худаг дээр нэмээд нийт 27 газарт гар худаг гаргаж, сэргээн засварласан байна.

Эрдэнэ суманд малчдын хүчээр гар худаг гаргах, сэргээн засварлах ажил харьцангуй урагштай явж байна. Энд гар худаг сэргээн засварлах ажлыг багийн засаг даргын ажлын нэг хэсэг болгож, нийт багийн хэмжээнд малчид гар худаг гаргах, сэргээн засварлахад гар бие оролцох зохион байгуулалтад орохыг зорьж байна. Иймд малчдын гар худаг гаргах ажил урагштай явж байна гэж бодогдохоор байна. Улаанбадрах, Хөвсгөл сумдын хувьд худгийн ажлыг сумаас удирдан явуулж байна.

Мөн Хөвсгөл суманд малчдын хүсэлтээр, баг дээр гар худгийн бригадыг зохион байгуулж, төслөөр орж ирсэн багаж хэрэгслийг үнэгүй ашиглуулан, өвөлжөөний худгуудыг засварлахаар төлөвлөж байна.

Хүснэгт 4.6.61 Сумдад гар худгийн ажил явагдсан байдал.

Эрдэнэ	2004 онд: ЗДТГ-ын санаачлагаар 1 худаг гаргасан, малчид 5 худаг сэргээн засварласан. 2005 онд: Баг болон малчид 1 худаг шинээр гаргаж, 1 худгийг сэргээн засварласан ба одоогоор 2 газарт сэргээн засварлах ажил хийгдэж байна.
Улаанбадрах	2004 онд: Малчид шинээр 1 худаг гаргасан 2005 онд: ЗДТГ-ын санаачилгаар 4 худаг шинээр гаргасан. (Сумынхаа 80 жилийн ойн ажлын хүрээнд)
Хөвсгөл	2004 онд: Малчид 1 худаг гаргасан, ЗДТГ-ын санаачилгаар сумын төвийн орчимд 5 худаг сэргээн засварласан. 2005 онд: Малчид 1 худаг сэргээн засварласан.

Мөн энэ жил эхэлсээр төслөөр нийлүүлсэн багаж хэрэгслийг ашиглалгүйгээр Эрдэнэ суманд 2, Улаанбадрах суманд 1, Хөвсгөл суманд 2 худгийг тус тус сэргээн засварласан байна.

2) Материал, багаж хэрэгслийн ашиглалт ба төлбөрийг хураан авч буй байдал

Дараахь хүснэгтэд материал, багаж хэрэгслийн ашиглалт ба ашиглалтаас орж буй орлогын байдлыг харуулав.

Хүснэгт 4.6.62 Гар худгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын байдал (2004 онд)

Сумын нэр	Гар худгийн ажилд ашигласан	Бусад ажилд ашигласан
Эрдэнэ	Төслийн хүрээнд үзүүлэх сургалтаар гаргасан 2 худагт ус шавхах насос ашиглаж, ашиглалтын хөлсийг нь хураан авсан. Мөн бусад худгийг шинээр гаргахад насос ашиглуулж, ашиглалтын хөлсийг авсан. Насос ашиглуулснаас нийт 52000 төгрөгийн орлого (13000 х 4 худаг) орсноос гадна 2 худагт ашиглуулсны хөлсийг хурааж аваагүй байгаа. Бусад багаж хэрэгслийн ашиглалтын хөлсийг аваагүй. Мөн багуудад насос ашиглуулсны хөлсийг хурааж аваагүй байгаа.	Сумын төв талбай байгуулах ажил зэрэг ЗДТГ-ын ажлын хэрэгцээнд трактор ашигласан. Каск, ажлын хувцас зэргийг ЗДТГ-ын ажилд оролцож буй хүмүүс ашиглаж байгаа. Банз, балк зэрэг материал болон бээлийг ЗДТГ-ын ажилд хэрэглээд дуусгасан. Эдгээрийг ЗДТГ-ын ажилд зарцуулсан тул ямар нэгэн өртөг, хөлс аваагүй, мөн орны юмыг нь нөхөж аваагүй байгаа.
Улаанбадрах	Үзүүлэх сургалтаар гаргасан худгийн ажилд бүх төрлийн багаж, хэрэгсэл, төхөөрөмжийг ашигласан боловч ашиглалтын хөлсийг аваагүй. 1 худгаас нь хэрэглэсэн материалын үнийг авах ёстой боловч одоогоор авч чадаагүй байгаа. Өөр 1 худаг гаргахад насос ашиглуулсан боловч хугацаа богино (3 хоног), ашигласан малчин нь төлбөрийн чадваргүй зэргээс ашиглалтын хөлсийг аваагүй.	Алх, хөрөө, түрдэг тэрэг зэргийг сумын ЗДТГ –ын ажилд ажиглаж байгаа. Ашиглалтын хөлсийг нь авахгүй
Хөвсгөл	Үзүүлэх сургалтаар гаргасан 2 худагт материал, багаж хэрэгсэл, төхөөрөмжийг ашигласан. 1 худгаас нь 50000 төгрөг, нөгөө худгаас нь 53000 төгрөгийн орлого орсон. Сумын төвийн худаг засварлахад трактор ашигласан боловч ЗДТГ –ын санаачилсан ажил учир ашиглалтын хөлсийг аваагүй. Худгийн ажилд ажлын хувцас ашиглуулж, нийт 2300 төгрөгийн ашиглалтын хөлс хураан авсан.	Трактор болон шавхах насосыг сумын төвд худгаас ус татах, ус зөөвөрлөх ажилд ашиглуулснаар нийт 50000 төгрөгийн орлого орсон.

Хүснэгт 4.6.63 Гар худгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын байдал (2005 онд)

Сумын нэр	Гар худгийн ажилд ашигласан	Бусад ажилд ашигласан
Эрдэнэ	2005 онд шинээр гаргасан 1, сэргээн засварласан 1 худгийн ажилд ус шавхах насос ашиглагдсан ба одоогийн байдлаар 2 худгийн засварт насосыг зээлээр хэрэглүүлж байна. Ашиглалтын хөлс төлөх ёстойг бүгд ойлгож байгаа. Ус шавхах насосоос бусад багаж хэрэгслийг ч зээлээр хэрэглүүлж байгаа ч хөлс төлөлт хийгдээгүй байгаа. 2004 оноос хойших ашиглалтын хөлс төлсөн байдал ус шавхах насос 6 удаагийнх 69.760 төг, трактор 1 удаагийнх 40.000 төг байна.	Хог зайлуулах ажил зэрэг ЗДТГ-ын хэрэгцээнд трактор ашигласан. Каск, ажлын хувцас зэргийг ЗДТГ-ын ажилд оролцож буй хүмүүс ашиглаж байгаа. ЗДТГ-ын ажилд хэрэглэсний хөлсийг сумын худгийн санд төлсөн.
Улаанбадрах	2005 онд 4 худаг сэргээн засварлахад ашигласан боловч ЗДТГ-ын зохион байгуулсан ажил тул ашиглалтын хөлс төлөгдөхгүй.	Сумын ЗДТГ –ын ажилд ашиглаж байгаа. Ашиглалтын хөлсийг нь авахгүй.
Хөвсгөл	2005 онд 1 худгийн сэргээн засварлалтад ус шавхах насосыг ашигласан.	Трактор болон ус шавхах насосыг сумын төвийн ус түгээгчид сарын 20.000 төгрөгөөр ашиглуулж байгаа.

Эдгээр багаж хэрэгслүүдээс гар худаг гаргах, засварлах ажилд хамгийн их хэрэглэгдсэн нь шавхах насос болон трактор байлаа. Бусад багаж хэрэгслүүд ч сургалтаар гаргасан худгийн ажилд ашиглагдсан боловч түүний өртгийг хурааж аваагүй байна. Түүнээс хойш ашиглалтын хөлс төлөөд авч хэрэглэх хүн гараагүй бололтой, өгч, авсан тухай тэмдэглэл байхгүй байлаа.

Энэ удаа худалдан авсан материал (банз, балк, цемент)-ыг үзүүлэх сургалтаар гаргасан худагт ашиглаж, үнийг нь уг худгийг ашиглах малчдаас хураан авч, дараа дараагийн ээлжинд худаг гаргах малчдад зарах материалыг худалдан авахаар төлөвлөж байсан боловч ганцхан Хөвсгөл сум л дээрхи материалын өртгийн зарим хэсгийг нөхөн авснаас хэтрээгүй байна.

Эрдэнэ суманд сургалтаар гаргасан худагт дээрхи материалыг ашиглаагүй, ЗДТГ-ын хэрэгцээнд хэрэглэсэн боловч орны материалыг нөхөн аваагүй байна.

Улаанбадрах суманд материалын үнийг нөхөн төлүүлэх, багаж хэрэгсэл ашигласны хөлсийг хураан авах ажил тааруухан байна. Гар худгийн ажил нь бүх зардлыг уг худгийг ашиглах малчид гаргана гэсэн зарчмаар явагдаж байгаа болно. Үзүүлэх сургалтын явцад малчдын хариуцсан ажилчдын хоол унд, насосны шатахууны зардал нэлээн их гарснаас тухайлбал Улаанбадрах сумын ЗДТГ материалын үнэ, багаж хэрэгслийн ашиглалтын хөлсийг давхар нэхэмжлэн авахаасаа бэрхшээсэн тал ч байсан бололтой.

3) Материал, багаж хэрэгслийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт

1) Хадгалалт, хамгаалалтын байдал

2004 оны байдлаар 3 сумын аль алинд нь материал, багаж хэрэгслийн хадгалалт хамгаалалтын байдал хангалтгүй байлаа. Ялангуяа 9-р сарын мониторингийн үед багаж хэрэгслийн хадгалалт хамгаалалт муу, өгсөн авсан бүртгэл тэмдэглэл хийгдээгүй байдалтай байв. 11 –р сарын мониторинг хүртэл байдлыг сайжруулах хүсэлт тавьсны үр дүнд хадгалалт хамгаалалтын байдал сайжирсан боловч зарим багаж хэрэгсэл ор сураггүй алга болсон байснаас гадна шатны зориулалтын банз, бээлий, ажлын хувцас зэрэг хэрэглээд муудсан, хаягдсан зүйлүүд их байлаа.

2005 оны 9-р сарын байдлаар сумдын багаж хэрэгслийн хадгалалт хамгаалалт ямар байгаатай танилцахад сумд доторх багаж хэрэгслийн хадгалалт, хамгаалалтын талаарх үүрэг хариуцлагын хуваарь тодорхой болж ирсэн байлаа. Гэхдээ Улаанбадрах, Хөвсгөл сумдын нярав өөрчлөгдөхдөө багаж хэрэгслүүдийг хоорондоо сайтар хүлээлгэн өгч, авалцаагүй байна. Эвдэрсэн болон хэнд өгсөн хаана байгаа нь тодорхойгүй багаж хэрэгслийг нөхөж бүрдүүлэхийг зөвлөв. Нөхөж бүрдүүлэх зүйлс нь хөрөө, алх зэргийг хэлж байгаа бөгөөд гар худаг гаргах үзүүлэх сургалтын үеэр хэрэглэж, үрэгдсэн бээлий зэргийг хэлээгүй болно. 2005 оны 11 сард явуулсан сүүлчийн мониторингийн үеэр Эрдэнэ, Улаанбадрах сумдад эдгээр элэгдэж хорогдох зүйлсээс бусад багаж хэрэгслийн хадгалалт хамгаалалтын бүтэц, зохион байшуулалт бараг бий болсон байв.

ii) Багаж хэрэгслийн хадгалалт хамгаалалтын бүтэц, зохион байгуулалт

Төсөл хэрэгжүүлж эхлэх үед сум тус бүрийн багаж хэрэгслийн хадгалалт хамгаалалт, түрээслэлт, төлбөр хураамж хариуцагчдыг тодорхой болгож, хөтлөх тэмдэглэлийн загварыг үзүүлж багаж хэрэгслийн хадгалалт хамгаалалтын арга замыг танилцуулж байв. Гэхдээ хэрэг дээрээ тухайн ажлыг хариуцагч нь сумынхаа арга хэлбэрийн дагуу ажлаа гүйцэтгэж байлаа.

Эрдэнэ сум урьд өмнө хэрэгжүүлж байсан ажлын туршлага дээрээ тулгуурлан, багаж хэрэгсэл, төхөөрөмжийг ашиглуулах, ашиглалтын хөлсийг хураан авах ажлыг нэлээн зохион байгуулалттай арга хэлбэрээр явуулж байна.

Хүснэгт 4.6.64 Сумд дахь багаж, хэрэгсэл ашиглуулах бүтэц, зохион байгуулалт

Сумын нэр	Багаж хэрэгсэлийг ашиглуулах бүтэц, зохион байгуулалт
Эрдэнэ	Багаж хэрэгсэл ашиглуулах зөвшөөрлийг ХАА – н түшмэл өгдөг. Хадгалалт хамгаалалтыг Тамгын газрын нярав хариуцна. Төлбөрийг Тамгын газрын төрийн сангийн төлөөлөгч хураан авч бүртгэдэг. 1) Багаж хэрэгсэл ашиглахыг хүссэн хүн ХАА-н түшмэлд хандаж, ашиглалтын хөлсийг асууж, тохиролцоно. 2) Дараа нь Банкин дахь Сумын худгийн сангийн дансанд ашиглалтын хөлсийг төлөөд баримтыг нь Тамгын газрын төрийн сангийн төлөөлөгчид өгдөг. 3) ХАА-н түшмэл мөнгө төлсөн баримт дээр үндэслэн багаж хэрэгсэл олгох бичиг үйлдэж, тэмдэглэл хөтөлнө. 4) Тамгын газрын нярав багаж хэрэгсэл олгох бичгийг үндэслэн холбогдох багаж хэрэгслийг тавьж олгоно. (Бодит байдал дээр төлбөрийг дараа нь хийх тохиолдол ч байдаг)
Улаанбадрах	Багаж хэрэгсэл ашиглуулах зөвшөөрлийг ХАА – н түшмэл өгдөг. Хадгалалт хамгаалалтыг Тамгын газрын нярав хариуцдаг. Сумын худгийн санд багаж хэрэгслийн ашиглалтын хөлсийг төлүүлэх үед банкны төлбөр тооцооны асуудлыг ч ХАА-н түшмэл хариуцна. ХАА-н түшмэл багаж хэрэгсэл ашиглах хүсэлтийг хүлээн авч, нярав тавьж олгон, тэмдэглэл хөтөлдөг. Энэ үед ашиглалтын хөлсний тухай тайлбарлаж өгөх бөгөөд багаж хэрэгслийг ашигласны дараа хөлсийг нь нөхөн төлүүлдэг.
Хөвсгөл	Багаж хэрэгсэл ашиглуулах зөвшөөрлийг ХАА – н түшмэл өгдөг. Хадгалалт хамгаалалтыг Тамгын газрын нярав хариуцна. Сумын худгийн санд багаж хэрэгслийн ашиглалтын хөлсийг төлүүлэх асуудлыг ХАА-н түшмэл хариуцдаг. 1) Багаж хэрэгсэл ашиглахыг хүссэн хүн ХАА-н түшмэлд хандана. 2) Багаж хэрэгсэлийг авах хүн багаж хэрэгсэлийн тоо, төрөл, үнэ өртөгийн талаар няравтай тохиролцон бичиг үйлдээд багаж хэрэгслээ хүлээн авна. 3) Тамгын газрын нярав багаж хэрэгслээ буцаан аваад, ашиглалтын хөлсийг нь хураан авна. 4) ХАА-н түшмэл ашиглалтын хөлсийг сумын худгийн сангийн дансанд хийгээд тэмдэглэл хөтөлнө.

Сумдад худгийн ажлаас өөр ажил юмуу ЗДТГ-ын ажилд трактор болон бусад багаж хэрэгслийг ашиглах явдал нийтлэг байна. Ялангуяа Эрдэнэ сумын ЗДТГ-ын ажилд трактор болон бусад багаж хэрэгсэл их хэмжээгээр ашиглагддаг байна. Мөн сумдад багаж хэрэгсэл хариуцагч нь тэмдэглэл хийдэггүй, ашиглалтын хөлсийг ч хураан авдаггүй тохиолдол олонтаа тул багаж хэрэгслийг зүй зохистой ашиглаж байна гэж

хэлэхэд хэцүү санагдлаа. Цаашид ижил төрлийн төсөл хэрэгжүүлэх тохиолдолд сумдын багаж хэрэгслийг ашиглуулах бүтэц, зохион байгуулалт, журам, хариуцлагын тогтолцоог урьдчилан тодорхойлж, багаж хэрэгсэл түрээслэх маягтыг тогтоож, мониторингыг дамжуулан байнгын сургалт зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна.

4) Кампанит ажлын зар сурталчилгаа, гарын авлага тараах үйл ажиллагаа

Малчид гар худгийн кампанит ажлын агуулга, зорилгын тухай багийн дарга нараас болон багийн өдөрлөгийн үеэр сонсож мэдэж авсан байна. Гэвч Улаанбадрах, Хөвсгөл сумын малчид хангалттай мэдээлэл аваагүй байдалтай байв.

Судалгааны багийн зүгээс сумуудын ЗДТГ-т говийн нөхцөлд гар худаг гаргах ажлын гарын авлага(Хавсралт L-ыг үзнэ үү)-ыг тус бүр 30 ширхэгийг өгч сонирхсон малчдад тарааж өгөхийг хүсэв. Эрдэнэ сумын ЗДТГ сонирхсон малчдад гарын авлагыг тарааж өгсөн байсан бол Улаанбадрах сумын ЗДТГ огт тарааж өгөөгүй, Хөвсгөл сумын хувьд Судалгааны багаас өгсөн гарын авлага хаачихсан нь мэдэхгүй алга болсон байв. Энэхүү гарын авлагыг малчдад тарааж өгснөөр гар худгийн кампанит ажлын агуулга, зорилгыг ойлгуулж, сонирхлыг нь татаж чадна гэж найдаж байсан болно. Гэвч гарын авлага малчин бүрийн гар дээр хүрэлцээтэй очиж чадаагүйгээс бидний хүсэж байсан үр дүнд хүрсэнгүй гэж бодогдож байна. Иймд цаашид сурталчилгааны үйл ажиллагааг дахин өргөн далайцтай явуулах шаардлагатай байна.

Хүснэгт 4.6.65 Сурталчилгааны ажил ба малчдын ойлголтын төвшин

	Гар худгийн кампанийг сурталчилах үйл ажиллагаа	Гар худгийн кампаний талаар ойлголт авсан байдал.
Эрдэнэ	<ul style="list-style-type: none"> ЗДТГ-т самбар гарган сурталчилсан. Багийн дарга нараар дамжуулан мэдээлэл өгсөн, сонирхсон хүмүүст гарын авлага тараасан. 	Гар худгийн кампанит ажлын тухай мэдээлэл авсан хүмүүс хангалттай ойлголттой байгаа боловч нийт малчдын түвшинд авч үзвэл ойлголт муутай.
Улаанбадрах	<ul style="list-style-type: none"> 5 - р сард болсон малчдын өдрөөр сурталчилгаа, тайлбар хийсэн. Багийн өдрийн үеэр Багийн даргаас мэдээлэл хийсэн. 	Малчид кампанит ажлын тухай хангалттай ойлголт аваагүй, буруу зөв ойлголттой хүмүүс ч цөөнгүй байна.
Хөвсгөл	<ul style="list-style-type: none"> 11 сард мэдээлэл хийхээр төлөвлөж байсан боловч хийгээгүй. Багийн өдөр зэрэг үйл ажиллагааны үеэр зохих хэмжээгээр мэдээлэл хийж, асуусан хүмүүст тайлбарлаж өгч байгаа. 	Малчид кампанит ажлын тухай хангалттай ойлголт аваагүй.

Судалгааны явцад боловсруулсан гарын авлагад тулгуурлан ХХААЯ-наас говийн бүсэд гар худаг гаргах ажлын гарын авлага гаргахаар болж буй тул төслийн хүрээнд дахин гарын авлага гаргаагүй болно.

Гарын авлагыг зөвхөн аймаг ба засаг захиргааны байгууллагад хуваарилж өгөх бус малчин өрх бүрт тарааж өгөх нь зүйтэй.